УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Д/Д	СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОН ҮНДЭСЛЭЖ БАЙГАА БУСАД БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ХУУЛЬ ТОГТООМЖ	ТӨСӨВ (САЯ.ТӨГ)	ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ	ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН
ЗОРИЛГО: ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ СТАНДАРТЫГ ХЭРЭГЖҮҮЛЖ, ЧАНАРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООГ БЭХЖҮҮЛЭХ				
ЗОРИЛТ 1: Эрүүл мэндийн сайдаас тусгайлан үүрэг болгосон арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх				
1.1	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана. **Хэрэгжилтийн хувь 100%**	-	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	**НЭГ:** УНТЭ нь 2024 онд нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй дараах арга хэмжээний төлөвлөгөөнүүдээс эрүүл мэндийн байгууллага болон УНТЭ-ийн үйл ажиллагаатай шууд холбоотой арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажилласан. 1. “Эх,хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 2. “Хавдрын эсрэг” арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 3. “Харшлаас сэргийлэх” арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 4. “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 5. “Эрүүл идэвхитэй амьдрал” 2021-2024 оны арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 6. “Халдварт өвчинтэй тэмцэх,сэргийлэх арга хэмжээний 2022-2025 оны төлөвлөгөө батлах тухай 7. “Жендерт суурилсан болон гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 8. “Сэтгэцийн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай 9. “Эрүүл мэндийн салбар дахь хүүхдийн эрх, хамгааллын (2024-2026 он) арга хэмжээний төлөвлөгөө” батлах тухай 10. “Эрүүл мэндийн салбарт жендерийн эрх тэгш байдлыг хангах талаар баримтлах бодлого, 2021-2024 онд бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө **ХОЁР:** Нийт арга хэмжээний төлөвлөгөөний 2024 оны эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг ЭМЯ-ны НЭМГ-ын 2024.5.17-ны өдрийн 6/2094 тоот албан бичгийн дагуу гарган тайлагнаж эмнэлгийн ерөнхий захирлын 2024.05.30-ны өдрийн 1/915 албан бичгээр хүргүүлсэн.

				Нийт арга хэмжээний төлөвлөгөөний 2024 оны бүтэн жилийн хэрэгжилтийн тайланг ЭМЯ-ны НЭМГ-ын 2024.10.30-ны өдрийн 6/4416 тоот албан бичгийн дагуу гарган тайлагнаж эмнэлгийн ерөнхий захирлын 2024.11.20-ний өдрийн 1/1822 албан бичгээр хүргүүлсэн. **ГУРАВ:** Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хууль 2024 оны 01 сарын 12-ны өдөр батлагдаж 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн нийтээр дагаж мөрдөж эхэлсэнтэй холбоотойгоор ЭМЯ-наас 2024 оныг "Нийгмийн эрүүл мэндийг дэмжих" жил болгон зарласан. УНТЭ-ийн Нийгмийн эрүүл мэндийн албанаас НЭМҮТ-тэй хамтран 2024.05.08-ны өдөр нийт эмч нарт, 2024.11.20-ны өдөр резидент эмч нарт , 2024.12.03-ны өдөр нийт сувилагч нарт “Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилт” сэдвээр танхимын сургалт зохион байгуулсан. Зураг: Сургалтын үйл явц **ДӨРӨВ:** 2024.05.22-ны өдөр ЭМЯ, НЭМҮТ хамтран “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил-2024” өдөрлөгийг Сүхбаатарын талбайд зохион байгуулж УНТЭ нь 8 хүний бүрэлдэхүүнтэй баг бүрдүүлэн оролцсон. Тус өдөрлөгөөр “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай анхдагч хууль”-ийг иргэд, олон нийтэд, эрүүл мэндийн ажилтнуудад сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд мөн артерийн даралт болон цусан дахь сахарыг түргэвчилсэн аргаар хэмжих, хоол зүй, шим тэжээлийн зөвлөгөө өгөх, биеийн бүтэц, найрлага тодорхойлох зэрэг үйлчилгээг ард иргэдэд үзүүлж 150 орчим иргэд хамрагдсан.
1.2	Эрүүл мэндийн ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг	-	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Улсын нэгдүгээр төв эмнэлгийн Захиргаа, хүний нөөцийн албанаас ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих, эрүүлжүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, ХАБЭА-н чиглэлээр мэдлэг мэдээллийг нь дээшлүүлэх, цацрагийн аюулгүй байдлыг сайжруулах зэргээр нийт 13 ажил төлөвлөсөн арга хэмжээний төлөвлөгөөг эмнэлгийн ерөнхий захирлаар

	сайжруулах арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллана. **Хэрэгжилтийн хувь 90%**			батлуулан хэрэгжүүлж байгаа бөгөөд 2024 оны эхний 11 сарын байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 90%-тай байна. **Дэлгэрэнгүй тайланг хавсралтаар бэлтгэв. Хавсралт 1.**
1.3	Хүн амд зонхилон тохиолдох өвчин эмгэгээс сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох контент бэлтгэн, сурталчилна. **Хэрэгжилтийн хувь 100%**	-	Бүтээгдсэн контентын тоо	УНТЭ-ийн Нийгмийн эрүүл мэндийн алба нь 2024 онд хүн амд зонхилон тохиолдох өвчин эмгэгээс сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох контент бэлтгэн, сурталчлах чиглэлээр дараах ажлуудыг зохион байгуулсан. 1. ARSLAN.MN сайт нь нийгмийн хариуцлагын хүрээнд УНТЭ-ийн ЗАА, НЭМА-дуудтай хамтран ажиллаж 2024 оны туршид ард иргэдийн эрүүл мэндийн боловсролд зориулсан “Сувилагчийн зөвлөгөө” 5 видео контентийг бэлтгэж эмнэлгийн гадаад цахим хуудас болон фейсбүүк цахим хуудсанд байршуулж нийтийн хүртээл болгосон. http://unte.moh.gov.mn/post_categories/3 тус холбоосоор орж танилцана уу. 2. УНТЭ-ийн Сэргээн засах, уламжлалт эмчилгээний тасгийн хөдөлгөөн засалч Г.Туул 2024.05.15-ны өдөр Монгол HD телевизын “Өнөө өглөө” хөтөлбөрт “Тархины цус харвалтын дараах хөдөлгөөн заслын эмчилгээний ач холбогдол” сэдвээр зөвлөгөө мэдээлэл өгч харвалтын дараах байдалтай иргэдэд зориулсан хөдөлгөөн засах дасгал хөдөлгөөн зааж өгсөн. 3. УНТЭ-ийн НЭМА-ны хоолзүйч Э.Санчир нь 2024.02.19-ны өдөр Mongol HD телевизд Terminal 1.0, 2024.05.15-ны өдөр Mongol HD телевизийн Нүүдэл-Шийдэл нэвтрүүлэгт тус тус оролцож хүн амын дундах хооллолт, өвөрмөц бүлгийн хоол шим тэжээлийн талаар зөвлөгөө мэдээллийг өгсөн. Зураг. Ярилцлагын явцаас

				4. ЭМЯ-наас хэрэгжүүлсэн “Ирээдүйгээ бүү сор” тамхидалтыг бууруулах нөлөөллийн аянд УНТЭ нь үндсэн чиг үүргийн дагуу оролцож Уушги, харшил судлалын төвийн эмч нар “Электрон тамхины хор хөнөөл” сэдвээр зөвлөгөө мэдээлэл бүхий өсвөр үеийхэнд зориулсан контент бэлтгэж сошиал орчинд түгээсэн бөгөөд НЭМА-аас мэргэжлийн байгууллагын зорилтот бүлгийн хүн амд зориулан бэлтгэсэн ухуулга сурталчилгааны материал, мэдээ, мэдээллийг Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн албан ёсны мэдээллийн сувгууд болох цахим фэйсбүүк пэйж хуудас, хамт олны групп, гадаад дотоод цахим хуудсандаа байршуулж нийтэд түгээсэн.
1.4	Хүн амд хоолзүй, шим тэжээлийн болон нэн шаардлагатай өвчний үеийн хооллолтын боловсрол олгох зорилго бүхий сургалт зохион байгуулна. **Хэрэгжилтийн хувь 100%**	2.0 (үйл ажиллагаа-ны орлого)	Сургалтын давтамж,тоо, хамрагдсан хүний тоо	2024 онд Нийгмийн эрүүл мэндийн албанаас хүн амд хоолзүй, шим тэжээлийн болон нэн шаардлагатай өвчний үеийн хооллолтын боловсрол олгох зорилго бүхий дараах сургалт, арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд: 1. 2024 оны 1 дүгээр сард хамтран ажиллах гэрээний дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 30 ажилтанд НЭМА-ны хоолзүйч Э.Санчир “Хооллолт ба шим тэжээл” сэдэвт сургалт зохион байгуулсан. 2. НЭМА-ны хоол зүйч болон Дотоод шүүрэл судлал диабетийн төв хамтран Чихрийн шижин хэвшинж 2-той үйлчлүүлэгчдэд зориулсан “Хоол шим тэжээл” сэдэвт танхимын сургалтыг 2024.02.05-2024.05.15 хооронд нийтдээ 6 удаа зохион байгуулж, нийт 20 гаруй үйлчлүүлэгч хамрагдсан. 3. ЭМЯ, НЭМҮТ хамтран “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил-2024” өдөрлөгийг 2024.05.22-ны өдөр Сүхбаатарын талбайд зохион байгуулсан бөгөөд НЭМА-ны хоол зүйч нь биеийн бүтэц найрлага тодорхойлох Inbody аппаратаар 45 иргэнд хэмжилт хийж, чихрийн шижин өвчний үеийн болон эрүүл зөв хооллолт, таргалалтын үеийн хоол шим тэжээлийн зөвлөгөөг өдөрлөгт оролцсон иргэдэд өгсөн. 4. УНТЭ-ийн Бөөрний төвөөс 2024.03.14-ний Бөөр хамгаалах дэлхийн өдрийг “Тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлж, эмийн зохистой хэрэглээг эрхэмлэе” уриатайгаар тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд өдөрлөгийн хүрээнд НЭМА-ны хоол зүйч нь “Бөөрний өвчний үеийн хоол шим тэжээл, хооллолт” сэдвээр сургалт зохион байгуулж нийт 100 гаруй иргэд хамрагдсан. 5. УНТЭ-ийн НЭМА-ны хоолзүйч Э.Санчир нь хамтын ажиллагааны хүрээнд “АПУ” ХК-ийн эрэгтэйчүүд олноор ажилладаг “АПУ ТРЭЙДИНГ” ХХК-ийн түгээлтийн

				жолооч нарт 2024.03.12-2024.03.13 өдрүүдэд “Хооллолтын илчлэг тооцох арга, ажлын байрны онцлог хооллолт, стрессийн үеийн хоол шим тэжээл” сэдвүүдээр танхимын сургалт зохион байгуулж нийт 70 гаруй түгээлтийн жолооч нар хамрагдсан бөгөөд сургалтын төгсгөлд ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих цуврал контентод оролцож нийгмийн сүлжээгээр түгээсэн. 6. УНТЭ-ийн НЭМА-ны хоолзүйч Э.Санчир нь 2024.02.19-ны өдөр Mongol HD телевизд Terminal 1.0, 2024.05.15-ны өдөр Mongol HD телевизийн Нүүдэл-Шийдэл нэвтрүүлэгт тус тус оролцож хүн амын дундах хооллолт, өвөрмөц бүлгийн хоол шим тэжээлийн талаар зөвлөгөө мэдээллийг өгсөн. 7. УНТЭ-ийн НЭМА-ны хоолзүйч Э.Санчир нь 2024.05.01-ний өдөр Баганаур ХК-ийн 200 гаруй ажилтанд “Гэдэсний эрүүл мэнд, Хүнсний эрүүл ахуй, Хүнсний аюулгүй байдал” зэрэг сэдвүүдээр танхимын сургалт зохион байгуулсан.
1.5	Ажилтнуудын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах ажлын хүрээнд урлагийн сэтгэл заслын эмчилгээний аргыг нэвтрүүлнэ. **Хэрэгжилтийн хувь 100%**	-	Сэтгэл заслын эмчилгээнд хамрагдсан ажилтнуудын тоо	УНТЭ-ийн Нийгмийн эрүүл мэндийн албаны сэтгэцийн эмгэг судлаач, сэтгэл заслын эмч А.Оюунжаргал нь 2024 оны 12 сарын байдлаар эмнэлгийн 96 ажилтанд сэтгэлзүйн зөвлөгөө өгч, эмчилгээнд хамруулж эмчилж байна. Их эмч А.Оюунжаргал нь сэтгэл заслын эмчилгээндээ урлагийн сэтгэл заслын эмчилгээний дараах аргуудыг нэвтрүүлж эхлээд байна. 1) “Хүн байшин мод” одоогийн сэтгэлзүйн байдал, сэтгэлзүйн гэмтлийг илрүүлэх зургийн сорил; 2) Проектив сэтгэл заслын зурган картууд 3) Персона /Хувь хүний сэтгэл зүйн байдал, тулгамдаж буй асуудал, харилцааны зөрчлийг илрүүлэх, сэтгэл засах/ 4) Персонита /Хувь хүний сэтгэл зүйн байдал, бага насны сэтгэл зүйн гэмтлийг илрүүлэх, сэтгэл засах/ 5) Инук /Бага насны сэтгэл зүйн гэмтлийг илрүүлэх, сэтгэл засах/ 6) Oh card /Хувь хүний сэтгэл зүйн байдал, бага насны сэтгэл зүйн гэмтлийг илрүүлэх, сэтгэл засах/ 7) Амьдрахын тулд уучил /Уй гашуутай ажиллах, сэтгэл засах/ 8) EQ- /хүүхдийн сэтгэл хөдлөлтэй ажиллах/ картууд зэрэг шинэлэг аргуудыг ашиглаж байна. Мөн ажилтнуудын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр шинэ сувилагч нарт “Ажлын байранд дасан зохицохуй” “Стресс менежмент” сэдвээр 3 удаа, Зүрхний төв болон Ариутгал халваргүйтгэлийн тасгийн хамт олонд “Ажлын байран дээрхи эерэг уур амьсгал” сэдвээр проектив зурган картын аргаар бүлгийн сэтгэл засал эмчилгээг 2 удаа, нийт ажилчдад “Сэтгэцийн эрүүл мэнд ба сэтгэл зүйн сайн сайхан байдал” “Стресс ба таргалалт” сэдвээр 2 удаагийн сургалтыг тус тус зохион байгуулсан.

				 Зураг. Сэтгэц, сэтгэл заслын эмч А.Оюунжаргал
ЗОРИЛТ 2: Эрүүл мэндийн үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэх /MNS 7014:2023/				
2.1	“Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS 7014:2023 стандартыг хэрэгжүүлнэ, төлөвлөгөө боловсруулан ажиллана. **Хэрэгжилтийн хувь 90.0%**	-	Батлагдсан төлөвлөгөө	1. УНТЭ-ийн ЭМТҮЧАБА-аас “Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага” MNS7014:2023 стандартыг хэрэгжүүлэн ажиллахаар 7 заалтын хүрээнд 23 ажил хийхээр төлөвлөсөн төлөвлөгөөг эмнэлгийн захирлаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 2024 оны эхний 11 сарын байдлаар 91.7%-тай байна. 2. Стандартыг нийт ажилтнуудад таниулах, мэдээлэх зорилгоор ЭМТҮЧАБА-аас нийт эмч нарын яриа, сувилахуйн нэгдсэн яриа, ахлах сувилагч нарын яриа, амбулатори, цахим бүртгэл, эмнэлгийн хэрэгсэл, аж ахуй, үйлчилгээ, хангамж түгээлтийн албаны 350 гаруй ажилтнуудад сургалт зохион байгуулсан.  Зураг. Сургалтын үйл ажиллагаа **Стандартыг хэрэгжүүлэх батлагдсан төлөвлөгөө, төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хавсралтаар бэлтгэв. Хавсралт 2.**

2.2	Тусгай хэрэгцээт үйлчлүүлэгчтэй харилцах эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэнэ. **Хэрэгжилтийн хувь 100%**	-	Бэлтгэгдсэн мэргэжилтний тоо	Эрүүл мэндийн байгууллагуудад дохионы хэлмэрчийг ажиллуулах, сонсголгүй, хэл ярианын бэрхшээлтэй иргэдийг чирэгдэлгүй эмнэлгийн тусламж үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор амбулаторийн хэсэгт дохионы хэлний сургалтанд хамруулсан сувилагч, цахим бүртгэгч нийт 4 ажилтныг мэдлэг сэргээх сургалтад хамруулан ажиллуулж байна. Мөн хэвтүүлэн эмчлэх төв, тасгуудаас ЧХХМЗТ, МХНТ-ууд тусгай хэрэгцээт үйлчлүүлэгчтэй харилцах сувилагч бэлтгэн, анхан шатны сургалтанд хамруулан ажиллуулж байна.
2.3	Үйлчлүүлэгчийг дэмжих алба байгуулна. **Хэрэгжилтийн хувь 70%**	-	– Батлагдсан тушаал – Шийдвэр – Ажиллах дүрэм	УНТЭ-ийн Захиргаа, хүний нөөцийн албанаас 2024.11.25-ны өдрөөс эхлэн Амбулаторийн тусламж үйлчилгээ хариуцсан их эмчээр Б.Номин-Эрдэнэ эмчийг томилон ажиллуулж байгаа бөгөөд тус эмч нь үндсэн чиг үүргийн хувьд үйлчлүүлэгчид шаардлагатай тусламж үйлчилгээг хариуцан ажиллана. Цаашид эмнэлгийн шинэчилсэн бүтцээр үйлчлүүлэгчийг дэмжих албыг байгуулан, ажиллах дүрмийг батлуулан, шаардагдах төсөв, төлөвлөгөөтэй бүрэн бүтцээр ажиллуулахаар төлөвлөсөн.
2.4	Нийт ажилтнуудын харилцаа хандлагад хяналтын хуудсаар үнэлгээ хийх, үнэлгээний дүнд суурилсан сургалт арга хэмжээг зохион байгуулна. **Хэрэгжилтийн хувь 100%**	-	– Боловсруулсан хяналтын хуудас – Үнэлгээний тайлан – Үйл ажиллагааны тайлан	MNS 7014:2023 Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага стандартыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийт ажилтнуудын харилцаа хандлагад хяналтын хуудсаар үнэлгээ хийх, үнэлгээний дүнд суурилсан сургалт арга хэмжээг зохион байгуулах зорилго тавьсны дагуу 2024 онд дараах ажлуудыг зохион байгуулсан. 1. Нийт захиргаа, эмнэлзүйн 11 алба, дэмжих үйлчилгээний 4 алба, эмнэлзүйн 24 төв, тасгийн дарга, эрхлэгч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тус ажлыг тусгаж, хэрэгжүүлэн ажиллахыг үүрэг болгосон. 2. Нийт алба, төв, тасгууд тусламж үйлчилгээний онцлогийг тусгасан хяналт үнэлгээний аргыг хэрэглэн ажилтнуудын харилцаа, хандлагад хяналт тавин ажилласан. 3. УНТЭ-ийн ёс зүйн салбар хороо нь 2024.01.17-ны өдөр АШУҮИС-ийн харилцааны тэнхимийн багш С.Наранчимэгтэй хамтарч тус стандартыг танилцуулах сургалтыг төв, тасгийн дарга эрхлэгч нарт зохион байгуулсан. 4. 2024.02.24-ний өдөр Улсын нэгдүгээр төв эмнэлгийн удирдлагын санаачлагаар алба, төв, тасгийн дарга, эрхлэгч нарыг хамруулсан “Удирдах ажилтны зөвлөгөөн”-ийг зохион байгуулсан бөгөөд тус сургалтанд Удирдлагын академийн захирал, Удирдахуйн ухааны доктор Д.Сүрэнчимэг “Байгууллагын соёл, бид ямар соёлыг бүтээсэн бэ?” сэдвээр сургалт хийж, цаашид сайжруулах чиглэлээр санал солилцож хэлэлцүүлсэн. 5. ЗХНА-аас 2024.05.22-ны өдөр Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн комиссар Д.Балдандоржтой хамтран “Эрүүл мэндийн байгууллагад

				холбогдох асуудлууд, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх нь” сэдвээр УНТЭ-ийн нийт эмч, төв, тасгийн дарга, эрхлэгч нарт сургалт зохион байгуулсан. 6. УНТЭ-ийн Сувилахуйн албанаас нийт 7 чиглэл 50 үзүүлэлт бүхий хяналтын хуудсыг боловсруулан сувилагч, тусгай мэргэжилтний үйл ажиллагаанд хяналт тавьж байна. Үүнд: 1) Ажлын цаг ашиглалт /1-6/ 2) Хувцаслалтын хэм хэмжээ /7-14/ 3) Биеэ авч явах соёл /15-21/ 4) Ээлж хүлээлцэлтийн үйл явц /22-32/ 5) Гар угаах, халдваргүйжүүлэлт /33-36/ 6) Хог хаягдлыг ангилан цуглуулах /37-46/ 7) Тусгаарлан сэргийлэлт /47-50/ Тус хяналтын хуудсаар мэс заслын тасгийн сувилахуйн багийн ээлж хүлээлцэлтэд нийт 81 удаагийн тойролт, дотрын сувилахуйн багийн ээлж хүлээлцэлтэд 72 гаруй удаагийн тойролт хяналт хийж, сувилагч тусгай мэргэжилтнүүдэд арга зүйн зөвлөгөө өгч байна. Үүнээс ажлын цаг ашиглалт, хувцаслалтын хэм хэмжээ, биеэ авч явах соёлын хэм, хэмжээ гэсэн үзүүлэлт хяналтын хуудсаар хийсэн үнэлгээгээр 94.2% байна.
2.5	Хаягжилт, цахим болон дуугүй хөтчийг шинэчилнэ. **Хэрэгжилтийн хувь 100%**	-	– Шинэчлэгдсэн хаяг – Дуугүй хөтчийн тоо	2024 онд Захирлын ажлын алба болон Эмнэлгийн хэрэгсэл, аж ахуй үйлчилгээ, хангамж түгээлтийн албадууд дараах хэсгүүдийн хаягжилтийг бүрэн хийж дуусгасан. 1. А блокын 2 давхарын коридорт байрлах 18 өрөөний хаяг 2. Амбулаорийн үүдний хэсэгт 2 ширхэг, хэвтэн эмчлүүлэх хэсэгт 1, дуугүй хөтөч, гэрэлтэй хаяг 3. Эрчимт эмчилгээний таазны гэрэлт хаяг буюу дуугүй хөтөч /4 талаас хаягжилт харагдана/  Зураг: Хаягжилтийн эх загвар болон суурилагдсан байдал Нийт шинэчлэх болон шинээр хийх хаягжилтийн судалгаа хийгдэж, төсөв шийдвэрлэгдсэн, хаяг хэвлэлтийн шатандаа явж байгаа тул хэрэгжилтийг 100% гэж тооцлоо.

ЗОРИЛТ 3: Чанарын менежментийн тогтолцоог нутагшуулах /MNS ISO 9001:2016 стандарт/				
3.1	Байгууллагын чанарын бодлогыг сурталчлах, мэдээлэх, хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулна. **Хэрэгжилтийн хувь 100%**	-	– Сургалтын тайлан – Хамрагдсан ажилтнуудын тоо	Байгууллагын чанарын бодлогыг сурталчлах, мэдээлэх, хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах чиглэлээр байдлаар дараах ажлууд хийгдлээ. 1. УНТЭ нь 2023 онд ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээний компани болох “УАЙ ЭС КОНСАЛТИНГ” ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажилласан бөгөөд 2023 оны 12 сард “Мон Майнинг Сертификейшн” ХХК-тай баталгаажуулалтын үйлчилгээний гэрээ байгуулан баталгаажилтын аудитад хамрагдан 3 жилийн хугацаатай итгэмжлэгдсэн. Тус ажлын хүрээнд байгууллагын хэмжээнд мөрдөн ажиллах “Чанарын менежментийн тогтолцоо” гарын авлагыг боловсруулан эмнэлгийн ерөнхий захирлаар батлуулж, чанарын бодлогоо тодорхойлсон. 2. 2024 оны 1-р улиралд нийт захиргаа, эмнэлзүйн 11 алба, дэмжих үйлчилгээний 4 алба, эмнэлзүйн 24 төв, тасгийн дарга, эрхлэгч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Байгууллагын чанарын бодлогыг сурталчлах, мэдээлэх”, стандартыг нутагшуулах ажлыг тусгаж, хэрэгжүүлэн ажиллахыг үүрэг болгосон. 3. 2024.02.24-ний өдөр Улсын Нэгдүгээр Төв эмнэлгийн удирдлагын санаачлагаар алба, төв, тасгийн дарга, эрхлэгч нарыг хамруулан зохион байгуулсан “Байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн”-д MNS ISO 9001:2016 стандартын хүрээнд батлагдсан Байгууллагын чанарын бодлогыг мэдээлж, Чанарын менежментийн тогтолцооны гарын авлагыг танилцуулан нийт удирдлагуудад тараасан. 4. Чанарын бодлогыг хэрэгжүүлэх, чанарын менежментийн тогтолцоог байнга үр нөлөөтэй байлгах зорилгоор ЧМТ MNS ISO 9001:2015 стандарт шаардлагын дагуу 14 журмыг шинэчлэн боловсруулж батлуулсан бөгөөд тус журмуудыг танилцуулах 8 удаагийн цуврал сургалтыг зохион байгуулж, 150 гаруй эмч, суралцагч эмч, чанарын багийн гишүүд, сувилагч нар хамрагдсан.

				 Зураг. Сургалтын мэдээлэл
3.2	Чанарын менежментийн тогтолцоо-шаардлага MNS ISO 9001:2016 стандартыг бүрэн нутагшуулна. **Хэрэгжилтийн хувь 100%**	-	– Хөндлөнгийн болон дотоод аудит хийсэн тоо – Тайлан	Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд ЧМТ MNS ISO 9001:2015 стандартын дотоод аудитын сургалтанд хамрагдан шалгалтанд тэнцэж аудиторын эрх авсан 32 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээс 14 аудиртой хамтран Захирлын ажлын албанаас нэгтгэн зохион байгуулж стандарт нэвтрүүлэх хамрах хүрээнд багтсан захиргааны болон дэмжих үйлчилгээний 28 алба, төв, тасаг, нэгжид стандартын аудит хийж үл тохирлын нэгдсэн тайланг гарган, удирдлагуудад танилцуулсан. 1. Зүрхний төв 2024.01.30 2. Мэдрэлийн эмнэлзүйн төв 2024.01.30 3. Бүдүүн шулуун гэдэсний мэс заслын тасаг 2024.01.30 4. ЦЭСЧШСТ 2024.01.31 5. Ерөнхий мэс заслын тасаг 2024.01.31 6. Уушги харшил судлалын төв 2024.01.31 7. Чих хамар хоолой судлал мэс заслын тасаг 2024.02.01 8. Эрүү нүүрний мэс заслын тасаг 2024.02.01 9. Эмнэлзүйн алба 2024.02.01 10. Эрхтэн шилжүүлэн суулгах төв 2024.05.28 11. Гастроэнтерологийн төв 2024.05.28 12. Нүд судлал, мэс заслын тасаг 2024.05.28 13. Мэдээлэл технологийн алба 2024.06.12 14. Техникийн алба 2024.06.12 15. Эм зүйн алба 2024.06.12 16. Ариутгал халдваргүйтгэлийн тасаг 2024.08.21 17. Халдварын сэргийлэлт, хяналтын алба 2024.09.04 18. Захиргаа, хүний нөөцийн алба 2024.09.04 19. Эдийн засаг, маркетингийн алба 2024.09.06 20. Яаралтай тусламжийн тасаг 2024.09.11 21. Санхүү бүртгэлийн алба 2024.09.11

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>
22. Сувилахуйн алба 2024.09.25
23. Эмнэлгийн хэрэгсэл, аж ахуй, үйлчилгээ, хангамж түгээлтийн алба 2024.10.02
24. Инженер байгууламжын алба 2024.10.07
25. Амбулатори 2024.11.06
26. Нийгмийн эрүүл мэндийн алба 2024.11.06
27. Сургалт эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааны алба2024.11.07
28. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдлын алба 2024.11.07

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН
<table>
<tr><td>Огноо:
2024.01.30</td><td>Байршил: Бүдүүн шулуун гэдэсний мэс заслын тасаг</td></tr>
<tr><td>Аудитын зорилт:</td><td>Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2016 стандартын нэвтрүүлэлт, стандартын талаарх ажилтны ойлголт болон шаардлагатай баримт бичгийн бүрдүүлэлтийн байдалд үнэлгээ хийх.</td></tr>
<tr><td>Хамрах хүрээ:</td><td>УНТЭ-ийн БШГМЭТ</td></tr>
<tr><td>Аудитын багийн ахлагч:</td><td>Аудиторууд:</td></tr>
<tr><td>ISO-ийн зөвлөх аудитор</td><td>1. Сургалт эрдэм шинжилгээ, инноваци эрхэлсэн дэд захирал П.Анхтуяа
2. ЗАА-ны дарга Ц.Амаржаргал
3. СА-ны дарга Ц.Амаржаргал
4. ЭМТҮЧАБА-ны мэс засал хариуцсан чанарын менежер С.Дашцогт
5. ЭМТҮЧАБА-ны эрсдэл, аюулгүй байдал хариуцсан менежер Б.Батчимэг</td></tr>
<tr><td>Аудитын шалгуур:</td><td>1. "Чанарын менежментийн тогтолцоо-Шаардлага" MNS ISO 9001:2016</td></tr>
<tr><td>Аудитад үчирсан саад тотгор:</td><td>Байхгүй</td></tr>
<tr><td>Аудитад хамрагдсан</td><td>БШГМЭТ-ийн эрхлэгч Э.Бат Өлзий
БШГМЭТ-ийн их эмч Ж.Ганцолмон
БШГМЭТ-ийн их эмч О.Зургаанжин
БШГМЭТ-ийн их эмч Б.Цогтгаа
БШГМЭТ-ийн их эмч Б.Түвшинтор
БШГМЭТ-ийн ахлах сувилагч М.Дуламсүрэн
Амбулаторийн тасгийн хавдрын эмч н.Намсрай</td></tr>
<tr><td colspan="2">Аудитаар илэрсэн үл тохирлууд:</td></tr>
<tr><td></td><td>1. MNS ISO 9001:2016 7.4 Холбоо харилцаа</td></tr>
</table>

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН
<table>
<tr><td>Огноо:
2024.02.01</td><td>Байршил: Эмнэлэгийн алба</td></tr>
<tr><td>Аудитын зорилт:</td><td>Чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001:2016 стандартын нэвтрүүлэлт, стандартын талаарх ажилтны ойлголт болон шаардлагатай баримт бичгийн бүрдүүлэлтийн байдалд үнэлгээ хийх.</td></tr>
<tr><td>Хамрах хүрээ:</td><td>УНТЭ-ийн Эмнэлэгийн алба</td></tr>
<tr><td>Аудитын багийн ахлагч:</td><td>Аудиторууд:</td></tr>
<tr><td>ISO-ийн зөвлөх аудитор</td><td>1. Сургалт эрдэм шинжилгээ, инноваци эрхэлсэн дэд захирал П.Анхтуяа
2. ЗАА-ны дарга Ц.Амаржаргал
3. ЭМТҮЧАБА-ны мэс засал хариуцсан чанарын менежер С.Дашцогт
4. ЭМТҮЧАБА-ны эрсдэл, аюулгүй байдал хариуцсан менежер Б.Батчимэг
5. ЗХНА-ны менежер И.Баасанхаргал
6. ЕМЗТ-ийн ахлах сувилагч П.Эрдэнэчимэг</td></tr>
<tr><td>Аудитын шалгуур:</td><td>1. "Чанарын менежментийн тогтолцоо-Шаардлага" MNS ISO 9001:2016</td></tr>
<tr><td>Аудитад үчирсан саад тотгор:</td><td>Байхгүй</td></tr>
<tr><td>Аудитад хамрагдсан</td><td>1. ЭА-ны дарга Л.Ундармаа
2. ЭА-ны статистич их эмч Э.Энх-Эрдэнэ
3. ЭА-ны их эмч З.Насанбат
4. ЭА-ны их эмч П.Ариунзаяа
5. ЭА-ны ШУЭ-ын менежер Э.Уранчимэг
6. ЭА-ны мэргэжилтэн Б.Энхцацгэл
7. ЭА-ны мэргэжилтэн Н.Дэлгэрмаа
8. ЭА-ны бага эмч Ц.Ундармаа
9. ЭА-ны бага эмч Ч.Энхбилэг
10.ЭА-ны бага эмч Ш.Санжидмаа</td></tr>
</table>
Зураг: Дотоод аудитын тайлан нэгж бүрээр бичигдсан байдал

“Менежментийн тогтолцооны гэрчилгээ эзэмшүүлэх, стандартын тэмдэглэгээ хэрэглэх гэрээ”-ний дагуу 2024 оны 12 дугаар сард багтаан магадлах аудит хийлгэх хүсэлтийг Мон Майнинг Сертификейшин ХХК-д хүргүүлж, 2024 оны 12 дугаар сарын 16-17 өдрүүдэд тус эмнэлэгт магадлах аудит хийлгэхээр бэлтгэж байна.
</td>
</tr>
<tr>
<td>3.3</td>
<td>Тасгийн батлагдсан процессын зураглалыг хэрэгжүүлж, мөрдөж ажиллана.

Хэрэгжилтийн хувь 100%</td>
<td>-</td>
<td>– Шалгуур үзүүлэлтийн хуудас
– Явцын үнэлгээний дүн
– Тайлан</td>
<td>УНТЭ нь 2023 онд ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх зөвлөх үйлчилгээний компани болох “УАЙ ЭС КОНСАЛТИНГ” ХХК-тай гэрээ байгуулан хамтран ажилласан бөгөөд зохих шаардлагуудыг биелүүлж, 2023 оны 12 сард “Мон Майнинг Сертификейшн” ХХК-тай баталгаажуулалтын үйлчилгээний гэрээ байгуулан баталгаажилтын аудитад хамрагдан 3 жилийн хугацаатай итгэмжлэгдсэн.
Тус ажлын хүрээнд Нийт 41 алба, төв, тасаг нэгжийн 634 чиг үүрэг, процесс зурагдаж эмнэлгийн захирлын 2023 оны А/137 тоот “Алба, төв, тасаг, нэгжийн чиг үүрэг, үйл явцын зураглалыг батлах тухай” тушаалаар батлагдсан.
Чанарын менежментийн тогтолцоог нэвтрүүлэх ажлын хүрээнд ЧМТ MNS ISO 9001:2015 стандартын дотоод аудитын сургалтанд хамрагдан шалгалтанд тэнцэж аудиторын эрх авсан 32 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээс 14 аудиртой хамтран Захирлын ажлын албанаас нэгтгэн зохион байгуулж стандарт нэвтрүүлэх хамрах</td>
</tr>
</table>

				хүрээнд багтсан захиргааны болон дэмжих үйлчилгээний 28 алба, төв, тасаг, нэгжид стандартын аудит хийж үл тохирлын нэгдсэн тайланг гарган, удирдлагуудад танилцуулсан. Аудитын явцад процессын дахин үнэлгээ хийсэн АХТ, ЯТТ-ууд байсан бөгөөд АХТ-ийн процессын зургийг шинэчлэн зурсан.  Зураг: Төв, тасгийн чиг үүрэг болон процессын зураг Нийт хяналт хийсэн 28 тасаг нэгжид нийтлэг давтагдаж буй үл тохирлыг мэдээлсэн бөгөөд шинээр ажилд томилогдсон ажилтнуудад мэдээлэл хангалтгүй байна.
ЗОРИЛТ 4: **Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах**				
4.1	Эмнэлзүйн болон эмнэлзүйн бус эрсдэлийг үнэлэх, мэдээллийн системээр бүртгэж, эрсдэлийн нэгдсэн санг баяжуулна. **Хэрэгжилтийн хувь 100%**	-	– Эрсдэлийн нэгдсэн сан – Бүртгэгдсэн эрсдэл	УНТЭ-ийн ЭМТҮЧАБА нь Ерөнхий захирлын 2023 оны А/341 тоот “Эрсдэлийн удирдлагын багийн ажиллах журам” тушаал, ЭМС-ийн 2019 оны А/566 тоот тушаал, ЭМС-ын 2024 оны А/112 тоот тушаалын дагуу эмнэлзүйн болон эмнэлзүйн бус эрсдэлийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн **https://eburtgel.hdc.gov.mn** хаягаар бүртгэн эрсдэлийн сан үүсгэн ажиллаж байна. 2024 оны эхний 11 сарын байдлаар нийт 68 эрсдэл бүртгэгдсэн. Мөн ЭМТҮЧАБА нь ISO зөвлөх багаас өгсөн зөвлөмжийн дагуу fchm-chanar@fchm.edu.mn майлээр эрсдэлийг бүртгэн нэгдсэн сан үүсгэн ажиллаж байна. 2024 онд УНТЭ-ийн “Эрсдлийн үнэлгээ, эрсдлээс сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө 2024”-ийг боловсруулан эмнэлзүйн болон эмнэлзүйн бус 72 учирч болзошгүй эрсдэлийг үнэлж, эрсдэл бууруулах төлөвлөгөөг Эмнэлгийн ерөнхий захиралаар батлуулан ажиллаж байна. Мөн УНТЭ-ийн Эрсдлийн удирдлагын баг 2024 онд нийт 3 удаа хуралдаж Инженерийн байгууламжийн алба, Эмнэлгийн техникийн алба, Дүрслэл оношлогооны төвийн Цөмийн онош зүйн тасгуудад буй эрсдэл, эрсдэлүүдийг бууруулах ажлын төлөвлөгөөг хэлэлцсэн Мөн 7 хоног бүрийн Баасан гариг бүрийн дэмжих албадын шуурхай хуралдаанд Ариутгалын тасаг, ИБА, МХНТ-ын агааржуулалт, ЭТА, Эм зүйн алба бусад дэмжих албадуудын эрсдэлүүдийг бууруулах талаар 30 гаруй асуудал хэлэлцсэн байна. Эмнэлгийн хэмжээний эрсдлийг магадлал үр дагавраар нь ангилж үзэхэд ноцтой эрсдэл-29, өндөр эрсдэл -32, дунд эрсдэл -11 мэдээлэгдсэн байна.

Зураг: Эрсдлийг түвшинг харуулсан график

Эрсдэл бууруулах үйл ажиллагааны үр дүнд ноцтой эрсдэл- 12, өндөр эрсдэл- 17, дунд эрсдэл- 29, бага эрсдэл-15 болж буурсан.



Зураг: Эрсдэл буурсан түвшинг харуулсан график

Тулгамждаж буй асуудалд ноцтой эрсдэлд /12/

1) Цацраг аюулгүй байдалтай холбоотой 3
2) Цөмийн оношилгооны аюулгүй байдалтай холбоотой -1
3) Тоног төхөөрөмжтэй холбоотой эрсдэл -2
4) Инженер байгууламжтай холбоотой эрсдэл- 6 тус тус байна.

				 Зураг: Эрсдлийн төлөвлөгөө болон мэдээллийн нэгдсэн сан
4.2	Мэс заслын өрөөний цаг ашиглалт, менежментийг сайжруулж, хяналт тавин ажиллана. **Хэрэгжилтийн хувь 100%**	-	– Мэс заслын хэсгийн цахим бүртгэлийн тайлан – Хяналт тавьсан тоо – Дүгнэлт зөвлөмж	Мэс заслын өрөөний цаг ашиглалт, менежментийг сайжруулж, хяналт тавин ажиллах чиглэлээр 2024 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ: **Нэг: Мэдээлэл технологийн албанаас:** Мэдээгүйжүүлэг, хагалгааны нэгдсэн тасгийн 3, 4 давхарын мэс заслын өрөөнүүдэд МТА-аас компьютер байршуулан E-health сүлжээнд холбож зарим анхан шатны маягтыг цахим болгох ажил хийгдэж байна. Үүнд : 1. Фильтерийн хэсэгт сувилагч мэс засалд орохоор ирсэн үйлчлүүлэгчийн ➢ Өвчтөн дуудсан цаг минут ➢ Өвчтөн фильтерийн хэсэгт ирсэн цаг ➢ Сэрээх өрөөнд шилжсэн цагийг бүртгэдэг болсон. 2. Мэс заслын өрөө болгон сүлжээнд холбогдон мэс заслын сувилагч нар eHealth программ дараах мэдээллийг цаг минутаар бүртгэж оруулдаг болсон. ➢ Мэдээгүйжүүлэг эмчийн ирсэн цаг ➢ Мэс заслын эмчийн ирсэн цаг ➢ Мэдээгүйжүүлэг бэлэн болсон цаг ➢ Мэс заслын сувилагч гар угаасан цаг ➢ Мэс засал эхэлсэн, дууссан цаг ➢ Мэс заслын төлөвлөгөө тайлан хэвлэх маягт 3. Мөн мэс засалд орох гэж байгаа үйлчлүүлэгчийг бүх сувилагч нар программ харах боломжтой болсон. 4. ЭМТҮЧАБА нь МХНТ-тай хамтран 2 удаагийн хяналт хийгдсэн

Хоёр: ЭМТҮЧАБА, ХСХА, МХНТ бусад албадууд

- 2024 оны 01 сарын 20-нд “МХНТ-ийн үйл ажиллагааг эрчимжүүлэх ажлын төлөвлөгөө 3 зорилт, 10 үйл ажиллагаатай боловсруулан гаргаж Эмнэлзүй эрхэлсэн дэд захиралаар батлуулан гаргаж хэрэгжилтийг ханган ажилласан.
- Уг төлөвлөгөөний хүрээнд МХНТ- аас “Цагийн менежмент сайжруулах нь” сэдэвт сургалтыг АУ-ны доктор Х.Баялагмаа нийт мэс заслын салбарын эмч нарт 2024 оны 03-р сард хийсэн.
- МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН АЛБА цахим цаг бүртгэлийг нэвтрүүлсэн.
- Мэс заслын өрөө бүр суурин компьютертай, дотоод сүлжээнд холбогдсон.Хагалгааны өрөө бүр 1 ширхэг хяналтын камер суурилуулсан.
- ЭМТҮЧАБА, ХАЛДВАРЫН СЭРГИЙЛЭЛТ ХЯНАЛТЫН АЛБА, МТА , ЭТА, ИБА, ЭМ ЗҮЙН АЛБА, СУВИЛАХУЙН АЛБА ХАМТАРСАН ХЯНАЛТУУДЫГ эхний хагас жилийн байдлаар 3 удаа хийсэн.



- ЭМТҮЧАБА-ны мэс заслын менежер V/01 – V/10-ны өдрүүдэд нийт 279 төлөвлөгөөт мэс засалд хяналт хийж үр дүнг гаргасан.
  Тус хяналтын үр дүнгээр:
  1. Эхний мэс засал цагтаа эхлэх (зүслэгийн цаг) – аар тооцож 84 байгаагаас, 42 мэс засал хоцорч эхэлсэн байгаа нь 50% тай байна.
  2. Нийт хоцорсон хугацаа – 1248 мин / 20 цаг48 мин/ - 542 минут / 9 цаг 2 минут/ гарсан байна.
  3. Мөн 5 сард илүү цаг гарсан өдрийн бүртгэлийг хийж Нийт хагалгааны өрөөний 83 тохиолдолоос 20 /24,09%/ - 1495 мин /24 цаг 55 минут / илүү цаг бүртгэгдсэн байна.

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td></td>
<td></td>
<td>
<table>
<tr><th>№</th><th>Тохиолдлын шалтгаан</th><th>Тоо</th><th>Хувиар</th></tr>
<tr><td>1</td><td>Эхний мэс засал хоцорсон тоо</td><td>13</td><td>64%</td></tr>
<tr><td>2</td><td>Эргэлтийн хугацаа илүү гарсан.</td><td>5</td><td>25%</td></tr>
<tr><td>3</td><td>Төлөвлөгөөт мэс засал хугацаа сунгагдсан</td><td>10</td><td>50%</td></tr>
<tr><td>4</td><td>Эмч хүлээлт үүссэн</td><td>2</td><td>10%</td></tr>
<tr><td>5</td><td>Багаж /дуран / хүлээсэн</td><td>2</td><td>10%</td></tr>
<tr><td>6</td><td>Мэс заслын давхарт өөрчлөлт орсон.</td><td>1</td><td>5%</td></tr>
<tr><td>7</td><td>Сэрээх өрөөнд хугацаа сунгагдсан.</td><td>1</td><td>5%</td></tr>
</table>
Дээрхи хяналт үнэлгээний дүнг эмнэлзүйн ярианд танилцуулж, мэс заслын зөвлөл хамтран уулзалт хийж цаашид хүлээгдэлгүй ажиллах удирдлагыг хэрэгжүүлж эхлээд байна.
</td>
</tr>
<tr>
<td>4.3</td>
<td>Тасаг, төвүүдийн тусламж, үйлчилгээний өвөрмөц шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэн боловсруулж, батлуулан, хяналт тавьж ажиллана.

Хэрэгжилтийн хувь 100%</td>
<td>-</td>
<td>– Шинэчлэн батлагдсан шалгуур үзүүлэлт
– Хяналт үнэлгээ
– Дүгнэлт, тайлан</td>
<td>
УНТЭ-ийн ЭМТҮЧАБА-аас 2024 онд дараах төв, тасгуудын тусламж үйлчилгээний 22 өвөрмөц шалгуур үзүүлэлтүүдийг шинэчлэн боловсруулж эмнэлгийн захирлын 2024 оны А/381 тоот “Хяналтын хуудас, шалгуур үзүүлэлт батлах тухай” тушаалаар батлуулсан.Үүнд:

ЭМТҮЧАБА
Амбулатори
Ерөнхий мэс заслын тасаг
Мэдээгүйжүүлэг, хагалгааны нэгдсэн тасаг
Яаралтай тусламжийн тасаг
Эрчимт эмчилгээний тасаг
Сувилахуйн алба
Халдварын сэргийлэлт, хяналтын алба
Эмнэлзүй эмгэг судлалын нэгдсэн лаборатори
Дүрслэл оношилгооны төв
Эм зүйн алба

<table>
<tr><th>Шалгуур үзүүлэлтүүд</th><th>Түвшин</th><th>Чиглэл</th></tr>
<tr><td colspan="3">ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОО ХЭМЖЭЭНИЙ НИЙТЛЭГ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ</td></tr>
<tr><td>Хэвтэн эмчлүүлэгчийн сэтгэл ханамжийн хувь</td><td>85%-иас дээш</td><td>ЭМТҮЧАБА Амбулатори</td></tr>
<tr><td>Амбулаториор үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн хувь</td><td>75%-иас дээш</td><td>Амбулатори</td></tr>
<tr><td>Сувилахуйн анхан шатны бичиг, баримт хөтлөлтийн хувь</td><td>90%-иас дээш</td><td>Сувилахуйн алба</td></tr>
<tr><td>Эмчилгээ/сувилгааны стандарт, заавар мөрдөлтийн хувь</td><td>90%-иас дээш</td><td>ЭМТҮЧАБА</td></tr>
</table>
</td>
</tr>
</table>

					АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД			
					Эмнэлгээр үйлчлүүлэх үедээ унаж, гэмтсэн тохиолдлын тоо	5%-иас бага	ЭМТҮЧАБА	
					Гар угаах хугацааны мөрдөлтийн хувь	85%-иас дээш	Халдвар хамгаалал	
					ЭТҮХХ-ын эрсдлийн дундаж түвшин	10%-иас доош		
					Өндөр эрсдэлт эмийн хаягжилт, танилцуулга	85%-иас дээш	Эм зүйн алба	
					Эмнэлэгт тохиолдсон холголт цооролтын тохиолдлын хувь	10%-иас доош	Сувилахуйн алба	
					Үйлчлүүлэгч танихтай холбоотой гарсан алдаа, зөрчлийн тоо	10%-иас доош		
					Төлөвлөгөөт мэс засал цагтаа эхэлсэн хувь	70% дээш	Мэдээгүйжүүлэг, хагалгааны нэгдсэн тасаг	
					Хагалгааны дараа сэрээх өрөөнд 3 цагаас илүү байлгасан үйлчлүүлэгчийн хувь	10% доош		
					Сэрээх өрөөнд байгаа өвчтөний биеийн халуун 35,5 ба түүнээс доош болсон тохиолдлын хувь	20% доош		
					Яаралтай тусламжийн тасагт 72 цагийн дотор тухайн оношоор буцаж ирсэн үйлчлүүлэгчийн хувь	10% доош	Яаралтай тусламж	
					Яаралтай тусламжийн тасагт ирсэн үйлчлүүлэгчийг 12 цагийн дотор шийдвэрлэсэн хувь	90-100%		
					Үжилтэй эмчлүүлэгчид SOFA үнэлгээ хийсэн хувь	100%	Эрчимт эмчилгээ	
					Үйлчлүлэгч эрчимтийн тасагт 48 цагийн дотор буцаж ирсэн хувь	10% доош		
					Амьсгалын аппаратаар удирдаж буй өвчтөнд тайвшруулалтын зэргийг үнэлсэн хувь /RAAS үнэлгээ/	100%	Эрчимт эмчилгээ	
					Яаралтай шинжилгээний хариуг ТАТ хугацаанд багтаан гаргах (ЦЕШ 30 минутын дотор, биохими 1 цаг)	90% дээш	Лаборатори	
					Үйлчлүүлэгчийг танин тодруулах явцад гарсан алдааны тоо	5-10% доош		
					Лабораторийн шинжилгээний хариу ноцтой өөрчлөлттэй гарсан тохиолдолд лабораториос эмчид яаралтай эргэн мэдээлсэн хувь	90% дээш	Лаборатори	
					Тодосгогчтой дүрс оношлогооны шинжилгээ хийхэд үйлчлүүлэгчээс зөвшөөрөл авсан хувь	100%	Дүрс оношилгоо	

<table>
<tr>
<td>4.4</td>
<td>Амбулаторид хийгдэх мэс засал, мэс ажилбар бусад үйлдлийн технологийн жагсаалт гаргах, батлуулах, мөрдөлтөд ижил мэргэжилтний үнэлгээ хийнэ.

Хэрэгжилтийн хувь 100%</td>
<td>-</td>
<td>– Батлагдсан жагсаалт
– Үнэлгээний тайлан</td>
<td>➢ УНТЭ-ийн Ерөнхий захирлын 2023 оны 09 сарын 04-ны А/232 тоот “УНТЭ-ийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд мөрдөж ажиллах стандарт зааварт, удирдамж үйлдлийн технологийг шинэчлэн батлах тухай” тушаалаар мэс засал, мэс ажилбарын 1118 жагсаалт гарсан.
➢ ЭМС-ын 2022 оны 02- р сарын 28-ны өдрийн А/118 тоот тушаал, ЭМДҮЗ-ийн 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 06-р тогтоолтой уялдуулан Амбулаториор хийгдэх мэс ажилбарын 158 үйлдлийн жагсаалтыг гаргасан бөгөөд эмнэлгийн захирлын 2024 оны А/402 тоот тушаалаар батлуулсан.
➢ Эмнэлгийн ерөнхий захирлын 2024 оны А/152 тоот “Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны дэргэдэх чанарын багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай” тушаалаар дотор, мэс засал, дэмжих алба, амбулатори тасгийн 33 чанарын баг томилогдон ажиллаж байна. Нийт чанарын багууд нь Эрүүл мэндийн даатгалын 06, 12-р тогтоолын хэрэгжилт болон өдөр тутам мөрдөгдөх стандарт зааврын хэрэгжилтэнд ижил мэргэжилтний үнэлгээг тогтмол хийж, сар бүрийн 05-ны өдөр даатгалын нэхэмжлэл үүсэх бүрт хяналт хийж байна.

АМБУЛАТОРИОР ХИЙГДЭХ МЭС АЖИЛБАРЫН ЖАГСААЛТ /2024 ОН/

Үндэслэл, эрх зүй:
1. ЭМДҮЗ-ийн 2024 оны 03 р сарын 29ны өдрийн 06-р тогтоол
2. ЭМС-ын 2022 оны 02- р сарын 28-ны өдрийн А/118 тоот тушаал

<table>
<tr><th>№</th><th>Тусламж үйлчилгээний ерөнхий жагсаалт</th><th>Тусламж үйлчилгээний нэр төрөл</th><th>ЭМД-руу илгээхдээг код, оношийн хамааралтай бүлэг</th><th>ЭМД-ын багцад хамаарах эсэх /Тийм, үгүй/</th><th>Төлбөрийн эхлэх хэмжээ</th></tr>
<tr><td colspan="6">Мэс заслын өвчний үзлэг, оношилгоо, эмчилгээ тусламж үйлчилгээ</td></tr>
<tr><td>1</td><td rowspan="14">Эрүү нүүрний эмгэгийн үеийн мэс ажилбар</td><td>Хөндлен байрлалтай шуд авах, саатсан агт араа авах</td><td>10401011</td><td>үгүй</td><td>160,000</td></tr>
<tr><td>2</td><td>Шүдний суурийн оройн үйлдэхэй авах</td><td>10401018</td><td>үгүй</td><td>100,000</td></tr>
<tr><td>3</td><td>Алькоголизаци ба хорог хийх</td><td>10401004</td><td>Үгүй</td><td>50,000</td></tr>
<tr><td>4</td><td>Тулгуур эдийн хагалгаа хийх /Лыцд/</td><td>10401009</td><td>Үгүй</td><td>60,000</td></tr>
<tr><td>5</td><td>Шүдний гаралтай ясны хальсны идэхт үрэвсэл нэхх</td><td>10401014</td><td>Үгүй</td><td>30,000</td></tr>
<tr><td>6</td><td>Тууцин засах</td><td>10401010</td><td>Үгүй</td><td>60,000</td></tr>
<tr><td>7</td><td>Хэл урулын хөөч уртасгах</td><td>10401012</td><td>Үгүй</td><td>70,000</td></tr>
<tr><td>8</td><td>Чихний сэтэрхий /2/өөх</td><td>11201022</td><td>Үгүй</td><td>45000</td></tr>
<tr><td>9</td><td>Боолт хийх</td><td>51300022</td><td>Үгүй</td><td>11,440</td></tr>
<tr><td>10</td><td>Атером авах</td><td>51300022</td><td>Тийм</td><td>28,080</td></tr>
<tr><td>11</td><td>Липом авах</td><td>51300022</td><td>Тийм</td><td>28,080</td></tr>
<tr><td>12</td><td>Эрүү нүүр орчмын хатиг нэхх</td><td>51300022</td><td>Тийм</td><td>28,080</td></tr>
<tr><td>13</td><td>Мэнэ авах</td><td>51300022</td><td>Тийм</td><td>28,080</td></tr>
<tr><td>14</td><td>Хэлэн дээрхи ургацаг авах</td><td>51300022</td><td>Тийм</td><td>28,080</td></tr>
<tr><td>15</td><td>Урууллын ургацаг авах</td><td>51300022</td><td>Тийм</td><td>28,080</td></tr>
<tr><td>16</td><td>Амны хөндийн ургацаг авах</td><td>51300022</td><td>Тийм</td><td>28,080</td></tr>
<tr><td>17</td><td>Жижиг бүлаа нэхх, том хэмжээтэй үү, ургацаг авах</td><td>51300022</td><td>тийм</td><td>28,080</td></tr>
<tr><td>18</td><td>Гадны биет авах</td><td>51300022</td><td>Тийм</td><td>28,080</td></tr>
<tr><td>19</td><td>Суурьалхийн орой тайрах</td><td>51300022</td><td>Тийм</td><td>28,080</td></tr>
<tr><td>20</td><td>Аюодагч сорви цэцлэх</td><td>51300022</td><td>Тийм</td><td>28,080</td></tr>
<tr><td>21</td><td>Хуучин сорви засах</td><td>51300022</td><td>Тийм</td><td>28,080</td></tr>
<tr><td>22</td><td>Тунгалгийн бүлчирхай авах /биопси/</td><td>51300022</td><td>Тийм</td><td>28,080</td></tr>
<tr><td>23</td><td>Шүлсний бүлчирхайн чулуу</td><td>51300022</td><td>Тийм</td><td>28,080</td></tr>
<tr><td>24</td><td>Боолт хийх</td><td>51300022</td><td>Тийм</td><td>11,440</td></tr>
<tr><td>25</td><td rowspan="5">Чих хамар хоолой эмгэгийн үеийн мэс ажилбар</td><td>Чихний сэтэрхий өөх /2тал/</td><td>11201022</td><td>Үгүй</td><td>45,000</td></tr>
<tr><td>26</td><td>Чихний хатиг нэхх</td><td>51300022</td><td>Тийм</td><td>28,080</td></tr>
<tr><td>27</td><td>Чихний бүлаа нэхх</td><td>51300022</td><td>Тийм</td><td>28,080</td></tr>
<tr><td>28</td><td>Гадна чихний хатиг нэхх</td><td>51300022</td><td>Тийм</td><td>28,080</td></tr>
<tr><td>29</td><td>Чихний атером авах</td><td>51300022</td><td>Тийм</td><td>28,080</td></tr>
</table>
</td>
</tr>
<tr>
<td>4.5</td>
<td>“Тусламж үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдал" заавар болон хяналтын хуудас боловсруулж мөрдөн ажиллана.

Хэрэгжилтийн хувь 70%</td>
<td>-</td>
<td>– Батлагдсан заавар
– Хяналтын хуудас Тайлан</td>
<td>➢ УНТЭ-ийн Сувилахуйн алба нь анх 2018 онд эмнэлгийн эрдмийн зөвлөлийн хурлаар 32 удирдамж хэлэлцүүлэн батлуулсны дотор “Үйлчилгээ үзүүлэгчийн аюулгүй байдлын удирдамж” хяналтын хуудасны хамт батлагдсан. 2021 онд хөдөлмөрийн тухай хуулийг шинэчлэн найруулж баталсан бөгөөд дагаад хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн эрх зүй, хөдөлмөрийн аюулгүй байдлыг зохицуулсан тушаал шийдвэрүүд шинэчлэгдсэн тул 2024 онд тус удирдамжийг дахин шинэчлэн боловсруулж эхлээд байна.
➢ Удирдамжийн гол агуулга нь “Та аюулгүй байх нь үйлчлүүлэгч аюулгүй байна” гэсэн зарчмын хүрээнд бичигдэж байгаа бөгөөд техникийн, халдвар хамгааллын, орчны гэсэн 3 үндсэн агуулгын хүрээнд боловсруулагдаж байна.
➢ Сувилахуйн алба нь ХАБЭА ажилтан Ж.Урантөгстэй хамтарч сувилахуйн тусламж үйлчилгээг үзүүлэгч сувилагчийн “Ажлын байран дахь өдөр тутмын зааварчилгааны бүртгэл”-ийг дараах 7 чиглэлээр хийж, журнал болгон үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.</td>
</tr>
</table>

Үүнд:

1. Хувцаслалтын хэм хэмжээ
2. Тарилгын аюулгүй байдал
3. Цахим түүх хөтлөлт
4. Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах
5. Унаж бэртэхээс урьдчилан сэргийлэх
6. Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн хэрэглээ, зарцуулалт, хяналт тавих, ээлж бүрт хүлээлцэх
7. Халдварыг тандах заавар



Зураг. Аюулгүй ажиллагааны зааварчилгаа

- 2024 онд ЗАА-ны ХАБЭА-н ажилтан, ЗХНА-тай хамтран Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвөөр 32 ажлын байранд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэсэн. Үүнээс Сувилахуйн албаны хүсэлтийн дагуу
    1. ЦЭСЧШСТ-ийн сувилагч, туслах сувилагч, үйлчлэгч
    2. ЯТТ-ийн сувилагч, эрэмбэлэн ангилах мэргэжилтэн
    3. Физик эмчилгээ, уламжлалт эмчилгээний сувилагч
    4. МЭТ-ийн сувилагч
    5. Тусгай хог хаягдал халдваргүйтгэл хариуцсан сувилагч
    6. ЭЭТ-ийн сувилагч, туслах сувилагч
    7. ЭШСТ-ийн сувилагч гэсэн ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийгдсэн.

- Тус газраас ирсэн зөвлөмжийг удирдамжинд тусган боловсруулж, сувилагч нарын хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах талаар цаашид авч хэрэгжүүлэх ажлын зөвлөмжийг 2025 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

4.6	ДОТ-ийн Цөмийн онош зүйн хэсэгт Олон улсын атомын энергийн газрын дэмжлэгтэй Спект СТ аппаратыг хүлээн авч суурилуулан ашиглалтад оруулна. **Хэрэгжилтийн хувь 90%**	3,000.0 ОУАЭГ	– Гэрээ – Ашиглалтад оруулсан акт – Дүгнэлт	 УНТЭ-ийн Дүрс оношилгооны төвийн Цөмийн онош зүйн хэсэгт Олон улсын атомын энергийн газрын дэмжлэгтэй Спект СТ аппаратыг суурилуулахаар төлөвлөгдсөн бөгөөд суурилуулах хэсэгт барилгын засварын ажил хийгдсэн. Мөн Олон улсын атомын энергийн газар, MEDISO ХХК-ууд тоног төхөөрөмж худалдан авах гэрээ байгуулсны дагуу тухайн тоног төхөөрөмж үйлдвэрлэгдсэн. 2024 оны 11 сарын 28-ны өдөр Mediso ХХК-ийн зүгээс Спект СТ аппаратыг Олон Улсын Атомын Энергийн газарт хүлээлгэн өгөхөөр шийдвэр гарсан бөгөөд тухайн байгууллагаас Монгол улс руу тээвэрлэх болон тоног төхөөрөмж Цөмийн онош зүйн хэсэгт ирсний дараа угсрах асуудал яригдаж байна. Тоног төхөөрөмжийн хувьд захиалга хийгдэж баталгаажсаны дараа үйлдвэрлэл явагддаг, угсрах өрөөний барилгын ажлыг шалгаж тээвэрлэлт хийдэг зэрэг шалтгааны улмаас хүлээгдэл үүссэн. 2024 оны 12 сарын 10-ны өдрийн байдлаар ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна.
4.7	Соронзон резонанст томографи (MRI аппарат) аппаратыг хүлээн авч суурилуулан ашиглалтад оруулна. **Хэрэгжилтийн хувь 70%**	5,500.0 ЭМЯ-ны хөрөнгө оруулалт	– Гэрээ – Ашиглалтанд оруулсан акт – Дүгнэлт	2024 онд Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтаар 1.5TESLA бүхий MRI аппарат УНТЭ-т нийлүүлэгдэхээр шийдвэрлэгдсэн. УНТЭ-ийн техникийн алба нь MRI аппаратны техникийн тодорхойлолтыг эмч нарын багтай хамтарч боловсруулсан. Эмнэлгийн ерөнхий захирлын тушаалаар худалдан авах үнэлгээний хороо байгуулагдан ажлын хэсэг нь 2024 оны 07 сарын 31-нд нээлттэй тендер зарласан. Гэвч Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Сангийн яам зэрэгт гомдол гарч тендер хойшлогдож байсан ба одоо бүх тендрээс татгалзаж дахин зарлахаар шийдвэрлээд байна. 2024 оны 12 сарын 10-ны өдрийн байдлаар ажлын гүйцэтгэл 70 хувьтай байна.
ЗОРИЛТ 5: Оношилгоо, эмчилгээ, үйлчилгээний дэвшилтэт технологи, инновацийг нэвтрүүлэн нутагшуулах				
5.1	Элэг шилжүүлэн суулгах мэс засалд суулгац элэгний нөхөн засалд гялтан хальс ашиглах мэс заслыг нэвтрүүлнэ.	1 хүнд 3.0 (үйл ажиллагааны орлого)	Амжилттай хийсэн мэс заслын тоо	УНТЭ-ийн Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн Элэг шилжүүлэн суулгах баг нь элэг шилжүүлэн суулгах мэс засалд хэвлийн гялтан хальсаар элэгний судас нөхөн засах мэс заслыг 5 тохиолдолд амжилттай хийгээд байна.

	Хэрэгжилтийн хувь 100%			
5.2	Дурангийн хэт авиан хяналтан дор ходоодны өргөссөн судсыг боох эмчилгээний технологийг нэвтрүүлнэ (EUS) **Хэрэгжилтийн хувь 100%**	1 хүнд 10.0 (үйл ажиллагааны орлого)	Амжилттай хийгдсэн тохиолдлын тоо	Дурангийн хэт авиан хяналтан дор ходоодны өргөссөн судсыг боох эмчилгээний технологи буюу EUS 2024 онд нийт 90 тохиолдол амжилттай хийсэн.
5.3	Дурангаар ходоодны хавдрыг бүх давхаргаар бүтнээр нь хуулах эмчилгээний технологийг нэвтрүүлнэ (EFTR) **Хэрэгжилтийн хувь 50%**	1 хүнд 15.0 (үйл ажиллагааны орлого)	Амжилттай хийгдсэн тохиолдлын тоо	Тус технологийг нэвтрүүлэхэд шаардлагатай багажны төсөв шийдвэрлэгдээгүй түр хойшлогдсон боловч ажилбарыг хийх эмч, сувилагчийн багийг ажлын байрны сургалтаар бэлтгэсэн.
5.4	Эвэрлэг шилжүүлэн суулгах мэс заслыг нэвтрүүлнэ. **Хэрэгжилтийн хувь 100%**	1 хүнд 16.0 (үйл ажиллагааны орлого)	Амжилттай хийгдсэн тохиолдлын тоо	УНТЭ-ийн удирдлагууд болон Нүд судлал, мэс заслын тасгийн эрхлэгч С.Энхтуул, их эмч Т.Ундармаа нар 2024 оны 3-р сард БНЭУ-ын Хайдрабат хотын LV Prasad нүдний институт болон УНТЭ-ийн НСМЗТ-тай эвэрлэг шилжүүлэн суулгах мэс заслын чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулсан. НСМЗТ-ийн их эмч Т.Ундармаа нь 2023.10.01-ны өдрөөс 2024.01.01-ны өдрийг хүртэл БНЭУ-ын LV Prasad Eye Institute эмнэлэгт 3 сарын эвэрлэг шилжүүлэн суулгах мэс заслын фелловшип сургалтанд хамрагдан төгссөн. 2024 оны 5 дугаар сард их эмч Т.Ундармаа АНУ-ын Вирту сангийн эвэрлэгийн эмчтэй хамтран 7 хүнд эвэрлэг шилжүүлэн суулгах мэс засал хийж, 1 хүнд эвэрлэгийн үүдэл эс шилжүүлэн суулгах мэс заслыг Монгол улсад анх удаа амжилттай хийсэн. Цаашид тус мэс заслын технологийг бүрэн нутагшуулах зорилт тавин ажиллах бөгөөд энэ нь эвэрлэг бүрхүүлийн бүдэгшил болон эргэн сэргэх боломжгүй өвчлөл бүхий

				үйлчлүүлэгчид өөрийн эх орондоо тусламж үйлчилгээг бүрэн авах нөхцөлийг бүрдүүлэх юм.
5.5	Нүдний глауком өвчний үед даралт буулгах (MIGS) мэс заслын аргыг нутагшуулна. **Хэрэгжилтийн хувь 100%**	1 хүнд 2.0 - 5.0 (үйл ажиллагааны орлого)	Амжилттай хийгдсэн тохиолдлын тоо	УНТЭ-ийн Нүд судлалын мэс заслын тасаг нь АНУ-д төвтэй Вирту Сантай 15 дахь жилдээ хамтран ажиллаж буй бөгөөд 2024 оны хамтын ажиллагааны хүрээнд 05 дугаар 19-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдрүүдэд УНТЭ-ийн НСМЗТ болон Ховд аймгийн БОЭТ-д ажиллаж, иргэдэд үзлэг, оношлогоо, эмчилгээ, мэс засал эмчилгээнүүдийг үнэ төлбөргүй хийж, эмч, резидент эмч нарт ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулсан. Тус ажлын хүрээнд тасгийн их эмч О.Наранцэцэг Вирту сангийн глаукомын эмчтэй хамтран 5 хүнд нүдний даралтын мэс засал, үүнээс 3 хүнд MIGS мэс заслыг амжилттай хийсэн байна.
5.7	Ортогнатик буюу шаамий засах мэс заслын аргыг нутагшуулна. **Хэрэгжилтийн хувь 100%**	1 хүнд 5.0-8.0 (үйл ажиллагааны орлого)	Амжилттай хийгдсэн тохиолдлын тоо	Эрүү нүүрний мэс заслын тасаг нь ортогнатик буюу шаамий засах мэс заслыг 2024 онд нийт 5 тохиолдолд амжилттай хийсэн. Тус мэс засал нь эрүү нүүрний мэс заслын салбарын хөгжлийг тодорхойлдог мэс засал тул цаашид хөгжүүлэн ажиллах зорилго тавьсан.
5.8	Гэмтэл болон хавдрын дараах согогийн нөхөн сэргээх мэс заслыг нутагшуулна. **Хэрэгжилтийн хувь 100%**	1 хүнд 3.0 (үйл ажиллагааны орлого)	Амжилттай хийгдсэн тохиолдлын тоо	УНТЭ-ийн Эрүү нүүрний мэс заслын тасаг нь гэмтэл болон хавдрын дараах согогийн нөхөн сэргээх мэс заслыг нутагшуулах чиглэлээр 2024 онд дараах мэс заслуудыг хийсэн. 1. Хавдар авсны дараах нөхөн сэргээсэн тохиолдол-2 2. Эрүү тайрсаны дараах нөхөн сэргээлт -1 3. Хэл заслын хагалгаа-4
5.9	Мөч хадгалах зорилгоор доод мөчдийн артерийн судасны бөглөрлийн үед венийн судсыг артержуулах мэс заслын технологийг нутагшуулна.	1 хүнд 6.0 (үйл ажиллагааны орлого)	Амжилттай хийсэн мэс заслын тоо	2024 онд тус технологийг бүрэн нутагшуулахаар төлөвлөсөн боловч эхний хагас жилийн байдлаар Зүрхний төвийн судасны багийн эмч нарт хандсан үйлчлүүлэгч нар ихэвчлэн маш их оройтож (өвчний төгсгөлийн шатанд) хүндэрч ирж байсан бөгөөд 2024 оны сүүлийн хагас жилд тус мэс заслыг 2 тохиолдолд амжилттай хийсэн.

	Хэрэгжилтийн хувь 100%			
5.10	Артери венийн фистулын мэс заслын алсын хүрцэд микроскопын тусламжтайгаар судас залгах бичил мэс заслын технологийг нутагшуулна. **Хэрэгжилтийн хувь 100%**	1 хүнд 2.0 (үйл ажиллагааны орлого)	Амжилттай хийсэн мэс заслын тоо	Зүрхний төвийн судасны мэс заслын баг нь 2024 онд артери венийн фистулын мэс заслын алсын хүрцэд микроскопын тусламжтайгаар судас залгах бичил мэс заслыг 10 тохиолдолд амжилттай хийсэн. Энэ мэс заслын технологи нь бөөр орлуулах эмчилгээнд хамрагддаг үйлчлүүлэгчид 15-20 см судсыг бэлтгэн өгч, үйлчлүүлэгчийн диализд орох хугацааг уртасгаж өгдөг, амьдралын чанарыг нь сайжруулдаг дэвшилтэт технологи юм.
5.11	Үгийн аудиометрийн шинжилгээг нэвтрүүлнэ. **Хэрэгжилтийн хувь 100%**	1 хүнд 0,12.0 (үйл ажиллагааны орлого)	Шинжилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	Чих, хамар хоолой судлал, мэс заслын тасгаас үгийн аудиометрийн шинжилгээ хийхэд ашиглагдах тусгай үгийн таблицыг боловсруулан шинжилгээг хийхэд бүрэн бэлтгэж, Монгол улсад анхдагчаар орчин үеийн анагаах ухааны түвшинд үндэсний хэмжээнд мөрдөж ажиллах цоо шинэ технологи нэвтрүүлсэн. Чих, хамар хоолой судлал, мэс заслын тасгийн их эмч О.Байгалмаа нь 2024 онд БНСУ-ын “Raphael International” ТББ-тай хамтарсан УНТЭ-ийн ерөнхий захирал АУ-ны доктор Л.Бямбасүрэнгээр удирдуулсан төслийн хүрээнд үгийн аудиометрийн стандарт боловсруулсан.  *Зураг: Бэлтгэл ажил хийгдэж байгаа нь*

5.12	Цусны хавдрын бай эмчилгээний 2-3 дугаар эгнээний 3 бай эмчилгээг эмчилгээнд нэвтрүүлж үр дүнг тооцно. **Хэрэгжилтийн хувь 100%**	1 хүнд 140.0 (төсөл хөтөлбөр, даатгал)	Эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	Цусны эмгэг судлал, чөмөг шилжүүлэн суулгах төв нь 2024 оны эхний хагас жилд цусны хавдрын бай эмчилгээний 2-3 дугаар эгнээний 4 бай эмчилгээг эмчилгээнд нэвтрүүлж эмчилгээний үр дүнг хянаж байна. Үүнд: 1. Дасатиниб – 4 хүн 2. Понатиниб – 4 хүн 3. Жакави - 21 хүн 4. Тасигна - 13 хүнд тус бүр хийсэн. Тус эмүүдийг төрөөс төлбөрийг даах эм рүү оруулж өдрийн эмчилгээгээр уулгах болон АНУ-ын болон Японы бренд 2 эмийг олон улсын тусламжийн сангаас үнэ төлбөргүй авч уулгаж хянаж байна.
5.13	Үүдэл эсийг шүүх, боловсруулах хөлдөөх шинэ технологийг нэвтрүүлнэ. **Хэрэгжилтийн хувь 100%**	1 хүнд 10.0 (үйл ажиллагааны орлого, даатгал)	Үүдэл эс шүүж боловсруулсан тоо	УНТЭ нь үүдэл эсийг шүүх технологийн шинэ аппарат болох OPTIO машиныг худалдан авсантай холбоотой ЦЭСЧШСТ-ийн эмч нар үүдэл эсийг шүүх, боловсруулах хөлдөөх шинэ аргад суралцаж, мэргэжлийн инженер техникчдээс сургалт авч, шинэ аргаар өвчтний үүдэл эсийг шүүн боловсруулж 2024 онд ауто-үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээг 3 үйлчлүүлэгчид хийсэн.
5.14	3D мэс засал: Төрөлхийн согог болон том хэмжээний гэмтлийн үед 3D принтер ашиглан хувь хүнд тохирсон протезын мэс заслыг нэвтрүүлнэ. **Хэрэгжилтийн хувь 100%**	1 хүнд 21.0 (үйл ажиллагааны орлого)	Амжилттай хийсэн мэс заслын тоо	УНТЭ-ийн Хэрх үе судлал, үе сэргээх төвийн эмчийн баг нь төрөлхийн согог болон том хэмжээний гэмтлийн үед 3D принтер ашиглан хувь хүнд тохирсон протезыг захиалан хийх мэс заслыг 2024 онд 2 үйлчлүүлэгчид амжилттай хийсэн. Тус технологийг бүрэн нэвтрүүлсэнээр том хэмжээний ясны дутмагшил, мөчний хавдрын үед өвчтөнд тохирсон протезийг хэвлэн ашиглах боломжтой болсон. Үйлчлүүлэгчийн протезтэй амьдрах амьдралын чанарыг илүү сайжруулж өгөх давуу талтай.
5.15	Яс, зөөлөн эдийн хавдрын нөхөн сэргээх, мөч хадгалах	1 хүнд 50.0	Амжилттай хийсэн мэс заслын тоо	2024 оны эхний хагас жилд Хэрх үе судлал, үе сэргээх төвийн эмч нар нь яс, зөөлөн эдийн хавдрын нөхөн сэргээх, мөч хадгалах мэс заслыг тохиолдолд амжилттай хийсэн. Тус 1 тохиолдлын нэг нь үе дайрсан хавдартай 12 настай хүүд мөч хадгалах мэс заслыг амжилттай хийсэн тохиолдол байсан.

	мэс заслыг нутагшуулна. **Хэрэгжилтийн хувь 100%**	(үйл ажиллагааны орлого)		
5.16	Тохойн хиймэл үе солих, дурангийн мэс заслыг нэвтрүүлнэ. **Хэрэгжилтийн хувь 90%**	Дурангийн мэс заслыг 1 хүнд 6.4 (үйл ажиллагааны орлого)	Амжилттай хийсэн мэс заслын тоо	1. УНТЭ-ийн Хэрх үе судлал, үе сэргээх төвийн эмч нар өмнө нь Монгол Улсад хийгддэггүй байсан тохойн үений дурангийн мэс заслыг хийж эхэлсэн. 2. Тохойн хиймэл үе солих мэс заслын бэлтгэл ажил хангагдсан, тоног төхөөрөмж хүний нөөц бүрэн бэлтгэгдсэн, тус мэс заслыг хийх тохиолдол ховор байдаг тул одоогоор хийгдээгүй байна.
5.17	Өмөнгийн угтвар хими болон бай эмчилгээг нутагшуулна. **Хэрэгжилтийн хувь 100%**	1 хүнд 3.0 (даатгал)	Бай эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	Бүдүүн шулуун гэдэсний мэс заслын тасаг нь 2024 оны турш нийт 467 үйлчлүүлэгчид өмөнгийн бай эмчилгээ болон хими эмчилгээ хийсэн. Үүнээс өмөнгийн хими бай эмчилгээ 341, өмөнгийн тогтолцооны хими бай эмчилгээ 126 хийсэн байна. Мөн тус тасагт Золодекс суулгац тарилгыг анх удаа үйлчлүүлэгчид хийсэн бөгөөд энэ тариа нь үйлчлүүлэгчийн биед хэрэглэхэд хялбар, гаж нөлөө багатай, үр дүн сайтай бай эмчилгээний нэг хэлбэр юм. 2024 оны 02 дугаар сард Золодекс суулгац тариаг хийх аргачлалыг ажлын байран дээр Монос эм хангах нийлүүлэх байгуулагын эмч төлөөлөгч Гэрэлмаа гардан зааж өгсөн. Тус суулгац тариаг нийт 60 үйлчүүлэгч хийлгэсэн. Зураг: Суулгац тариаг хэрхэн хийх тухай сургалтын үеийн зураг
5.18	Байгалийн нүхээр мэс заслын сорьцыг гаргах болон хэвлийн дотор залгалт хийх	1 хүнд 2.0 (үйл ажиллагааны орлого)	Амжилттай хийсэн мэс заслын тоо	УНТЭ-ийн Бүдүүн шулуун гэдэсний мэс заслын тасаг нь 2024 онд шулуун гэдэсний эрт үеийн өмөнгийн мэс засал буюу TAMIS мэс заслыг МУ-д анх удаа нэвтрүүлж нийт 5 тохиолдлыг амжилттай хийсэн. TAMIS хагалгаа нь хоргүй, гэмтэл болон эрт үеийн өмөнтэй сонгогдсон өвчтөнүүдэд мэс заслын дараах өвчлөл багатай, бага зэргийн гэмтэлтэй мэс засал бөгөөд энэ ажилбарыг хийж нутагшуулсанаараа: ➢ Хошного дотуурх дурангийн бичил мэс засал (TEM)

	технологийг нэвтрүүлнэ. **Хэрэгжилтийн хувь 100%**			➢ Хошного дотуурх дурангийн мэс засал (TEO) ➢ Transanal Total Mesorectal Excision (taTME) мэс засал гэж нэрлэгддэг бөгөөд шулуун гэдэсний доод хавдартай өвчтөнүүдэд зориулсан уламжлалт мэс заслыг бага гэмтэлтэй шинэ хувилбараар хийх технологийг нэвтрүүлэх суурь болж байна.
5.19	Харвалтын үндэсний шалгуур бүлэн уусгах эмчилгээ, бүлэн авах эмчилгээ /time/-г нэвтрүүлнэ. **Хэрэгжилтийн хувь 100%**	1 хүнд бүлэн уусгах 7.0 бүлэн авах 24.0 (даатгал)	Бүлэн уусгах эмчилгээ хийгдсэн тохиолдлын тоо	УНТЭ-ийн Яаралтай тусламжийн тасгаас харвалтын үндэсний шалгуур бүлэн уусгах эмчилгээ, бүлэн авах эмчилгээ /time/-г нэвтрүүлэх чиглэлэр дараах ажлуудыг хийсэн. 1. 2024 оны 7 дугаар сард харвалттай ирсэн 1 үйлчлүүлэгчид бүлэн уусгах эмчилгээг, 10 сард бүлэн уусгах болон бүлэн авах эмчилгээг 1 үйлчлүүлэгчид нийт 2 тохиолдолд амжилттай хийсэн. 2. 2024 оны 10 сарын 25ны өдөр Мэдрэлийн эмнэлэгүйн төв, Яаралтай тусламжийн тасаг хамтран “Тархины харвалтын сэргийлэлт, орчин үеийн оношилгоо, эмчилгээний зарчим” сэдэвт багц цагийн сургалтыг зохион байгуулж, тус сургалтанд ЯТТ-ийн дарга, их эмч С.Алтансүх “Харвалтийн үндэсний шалгуур бүлэн уусгах эмчилгээ, бүлэн авах эмчилгээ”-ний талаар сургалт мэдээлэл хийсэн бөгөөд нийт танхимаар, цахимаар яаралтай тусламж болон мэдрэлийн чиглэлийн 120 гаруй эмч нар хамрагдсан. 3. 2024 оны III дугаар улиралд “Харвалтын үеийн бүлэн уусгах эмчилгээний алгоритм”-ийг харуулсан мэдээллийн самбарыг хийж, хэвлүүлэн ЯТТ-ийн эрэмбэлэлтийн хэсэгт байршуулсан. Алгоритмын зураг

5.20	Элэгний сонгомол тодосгогчтой (Gd-EOB primovist) CPT-ийн оношилгоог нэвтрүүлнэ. **Хэрэгжилтийн хувь 70%**	1 хүнд 2.0 (үйл ажиллагааны орлого)	Оношилгоонд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	УНТЭ-ийн Дүрслэл оношилгооны төв нийт 10 үйлчлүүлэгчдэд тус оношилгоог хийхээр төлөвлөж элэгний сонгомол тодосгогч (Gd-EOB primovist) бодисыг эмзүйн албаар дамжуулан 10 ширхэг захиалж авсан. Эмчийн багаар MRI аппарат дээр уг шинжилгээг хийх протоколийг судлан туршиж бэлтгэл ажлыг хангаж байгаа бөгөөд шинэ MRI аппарат суурилагдсан үед оношилгоог хийж тусламж үйлчилгээнд нэвтрүүлэхэд бэлэн болсон. Одоо эмнэлэгт ашиглаж буй хуучин MRI аппаратын автомат тариур ажиллахгүй байгаа тул оношилгоог хийсэн тохиолдол байхгүй байна.
5.21	Элэгний анхдагч хавдрын тэжээгч судсаар бөглөх эмчилгээнд химийн тариа ялгаруулагч бөмбөлөг материалаар бөглөх эмчилгээг нэвтрүүлнэ. **Хэрэгжилтийн хувь 100%**	1 хүнд 5.0 (үйл ажиллагааны орлого)	Оношилгоонд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	УНТЭ-ийн Дүрслэл оношилгооны төв Deb-TACE буюу элэгний анхдагч хавдрын тэжээгч судсыг химийн тариа ялгаруулагч бөмбөлөг материалаар бөглөх эмчилгээг 2024 оны 2 сараас эхлэн эмнэлзүйд нэвтрүүлж эхэлсэн бөгөөд нийтдээ 7 тохиолдолд drug eluting beads ашиглан TACE эмчилгээг хийсэн байна. 
5.22	MR elastography шинжилгээг эмнэлзүйн практикт нэвтрүүлнэ. **Хэрэгжилтийн хувь 70%**	-	Оношилгоонд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	УНТЭ-ийн Дүрслэл оношилгооны төвийн эмчийн баг нь MRI аппарат дээр уг шинжилгээг хийх бэлтгэл ажлыг хангаж байгаа бөгөөд шинэ MRI аппарат суурилагдсан үед оношилгоог хийж тусламж үйлчилгээнд нэвтрүүлэхэд бэлэн болсон. Энэ нь элэгний хатуурлын зэргийг I-IV зэргээр илүү нарийвчлалтай гаргаж өгдөг оношилгоо юм. Одоо эмнэлэгт ашиглаж буй хуучин MRI аппарат нь тус оношилгоог хийх боломжгүй тул тохиолдол байхгүй байна.
5.23	Давсагны хорт хавдрыг хэвлийн дурангаар авах	1 хүнд 6.5 (даатгал)	Амжилттай хийсэн мэс заслын тоо	2024 онд Урологи-Андрологийн төв нь давсагны хорт хавдрыг хэвлийн дурангаар авах мэс засал 3 тохиолдолд амжилттай хийсэн.

	мэс заслыг нэвтрүүлнэ. **Хэрэгжилтийн хувь 100%**			
5.24	Давсагны хавдрыг шээдэг сүвээр дурандаж лазераар хуулан авах мэс заслыг нэвтрүүлнэ. **Хэрэгжилтийн хувь 100%**	1 хүнд 5.0 (үйл ажиллагааны орлого, даатгал)	Амжилттай хийсэн мэс заслын тоо	2024 онд Урологи-Андрологийн төв нь давсагны хавдрыг шээдэг сүвээр дурандаж лазераар хуулан авах мэс засал 1 тохиолдолд амжилттай хийсэн.
ЗОРИЛТ 6: Хүний нөөцийн хөгжлийг дэмжих, нийгмийн хамгаалал, ажилтнуудын ёс зүйг сайжруулах				
6.1	Байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ болон холбогдох эрх зүйн баримт бичгийг шинэчлэн боловсруулж батлуулна. **Хэрэгжилтийн хувь 100%**	5.0 (үйл ажиллагааны орлого)	– Шинэчилж батлагдсан журмууд – Хэвлэгдсэн гарын авлага	УНТЭ-ийн Захиргаа, хүний нөөцийн алба нь байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг захирлын 2024.02.27-ны өдрийн А/55 тушаалаар байгуулан ажиллаж байна. Уг ажлын хэсгийг Захиргаа, хүний нөөцийн албаны дарга П.Мөнхтуул ахалж, нарийн бичгээр Захиргаа, хүний нөөцийн албаны Хүний нөөцийн менежер О.Лхагвасүрэн, гишүүдээр Захирлын ажлын албаны дарга Ц.Амаржаргал, Санхүү, бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч Н.Урансүрэн, Сувилахуйн албаны дарга Ц.Амаржаргал, УНТЭ-ийн Үйлдвэрчний эвлэлийн хорооны гишүүн, Эмнэлзүйн эмгэг судлалын нэгдсэн лабораторийн их эмч Д.Нарантөгөлдөр, УНТЭ-ийн Үйлдвэрчний эвлэлийн хорооны гишүүн, Зүрхний төвийн сувилагч Д.Отгонзул, Хуулийн зөвлөх Ш.Нарантуяа нар ажиллаж байна. Байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд ажилтнуудаас санал хүлээн авах мэдээллийг нийт ажилтнуудад all@fchm.edu.mn албаны цахим шуудангаар 1. 2023.07.28-ны өдөр 2. 2023.10.02-ны өдөр 3. 2024.01.11-ний өдөр 4. 2024.05.16-ны өдөр тус хүргүүлсэн. Мөн телеграмм, вайбер, хамт олны фасебүүк групп дээр санал авах мэдээллийг ил тод байршуулсан.

				Байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд ирсэн ажилтнуудын саналыг ажлын хэсгийн гишүүд шинэчилж буй журманд тусган, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцсэн. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд өөрчлөлт оруулах ажлыг нэгтгэн боловсруулах ажил 90%-ийн гүйцэтгэлтэй байна.
6.2	Шаардлагатай албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж батлуулна. **Хэрэгжилтийн хувь 100%**	-	Батлагдсан албан тушаалын тодорхойлолт	УНТЭ-ийн Захиргаа, хүний нөөцийн алба нь албан тушаалын тодорхойлолт боловсруулахад аргазүйн зөвлөгөө авах, мэргэжилтэн томилуулах, хамтран ажиллах хүсэлтийг Төрийн албаны зөвлөлд 2024.11.04-ний 5/1736 тоот албан бичгээр хүргүүлсэн болно. 2024.11.25-ны өдөр Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага, аудитын газрын дарга Д.Нармандах “Байгууллагын чиг үүрэг, ажлын байрны шинжилгээ хийх, албан тушаалын тодорхойололт боловсруулах аргачлал” сэдвээр УНТЭ-ийн удирдах ажилтнуудад сургалтыг зохион байгуулсан. Төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүдэд жишиг болохуйц албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажилд Төрийн албаны зөвлөлөөс зөвлөн тусалж дэмжлэг үзүүлж ажиллахаар санал зөвшилцсөн болно.  Зураг. Сургалтын явцын зураг УНТЭ-ийн Захиргаа, хүний нөөцийн алба нь 111 албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулахаар тасаг, нэгжүүдээс албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулах эсэх асуудлаар санал авч байна. “Албан тушаалын тодорхойлолт /ажлын байр/”-ыг шинэчлэн боловсруулах 22 ажилтны бүрэлдэхүүнтэй Ажлын хэсгийг ерөнхий захирлын 2024.11.25-ны өдрийн А/371 тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийг Захиргаа, хүний нөөцийн албаны дарга П.Мөнхтуул ахлан ажиллаж байна. ЭМС-ын 2023 оны А/341 тоот “”Сувилахуй эрхэлсэн дэд захирал ажиллуулах тухай” тушаалын дагуу 2024 онд сувилахуй эрхэлсэн дэд захирлын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулсан.

6.3	Шаардлагатай ажлын байранд хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийлгэнэ. **Хэрэгжилтийн хувь 100%**	3.0 (үйл ажиллагааны орлого)	Хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийлгэсэн тайлан	УНТЭ-ийн Захирлын ажлын албаны ХАБЭА-н ажилтан Ж.Урантөгс, Захиргаа, хүний нөөцийн алба хамтран Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвд ээлжит хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх хүсэлт хүргүүлсэний дагуу 2024.07.08-нд Х/24/64 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулан 2024.09.19-2024.09.20-ны өдрүүдэд нийт 32 ажлын байранд хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээг хийлгэсэн. Тус нөхцөлийн үнэлгээний дүгнэлт зөвлөмж нь ХАБЭМТ-өөс 2024.10.29-ний өдрийн 510 тоот албан бичгээр ирсэн. Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэсэн ажлын байрууд: 1. ЭЭСНЛ, эд нийцэл молекул генетикийн хэсэг - Эд нийцэл, молекул генетикийн лаборант 2. ЭЭСНЛ, эд нийцэл молекул генетикийн хэсэг - Эд нийцэл, молекул генетикийн эмч 3. ЭЭСНЛ, Клиник химийн хэсэг - Клиник химийн лаборант 4. ЭЭСНЛ, Бактериологийн хэсэг - Бактериологийн лаборант 5. ЭЭСНЛ, Гистологийн хэсэг - Гистологийн эмч 6. ЭЭСНЛ, Гистологийн хэсэг -Гистологийн лаборант 7. ЭЭСНЛ, Биохимийн хэсэг - Биохимийн лаборант 8. Яаралтай тусламжийн тасаг - Их эмч 9. Яаралтай тусламжийн тасаг - Сувилагч 10. Яаралтай тусламжийн тасаг - Эрэмбэлэн ангилах мэргэжилтэн 11. Яаралтай тусламжийн тасаг - Туслах сувилагч 12. Яаралтай тусламжийн тасаг - Үйлчлэгч 13. Эм зүйн алба - Хими эмчилгээ найруулах эм зүйч 14. Эм олгогч, эд хариуцагч эм зүйч 15. Эм найруулагч 16. Эмнэлзүйн эм зүйч 17. Шил угаагч 18. Цусны эмгэг судлал, чөмөг шилжүүлэн суулгах төв -Сувилагч 19. Цусны эмгэг судлал, чөмөг шилжүүлэн суулгах төв -Туслах сувилагч 20. Цусны эмгэг судлал, чөмөг шилжүүлэн суулгах төв - Үйлчлэгч 21. Сэргээн засах эмчилгээний тасаг - Физик эмчилгээний сувилагч 22. Уламжлалт эмчилгээний тасаг -Уламжлалт эмчилгээний сувилагч 23. Мэдрэлийн эмнэлзүйн төв - Тархины судасны ангиографийн эмч 24. Мэдрэлийн сувилагч

6.4	Хүний нөөцийн чиглэлээр шинэ болон нийт ажилтнуудад зориулсан шаардлагатай мэдээллээр видео хичээлийн сан үүсгэж, түгээнэ. **Хэрэгжилтийн хувь 70%**	-	– Үүсгэсэн видео сан – Оруулсан мэдээллийн тоо	Улсын Нэгдүгээр Төв эмнэлгийн Захиргаа, хүний нөөцийн албанаас 1. Байгууллагын ерөнхий захирлын 2024.11.29-ний өдрийн А/380 тушаалаар батлагдсан “УНТЭ-ийн ажлын цаг бүртгэлийн журам”, 2. Байгууллагын ерөнхий захирлын 2024.12.03-ны өдрийн А/382 тушаалаар батлагдсан “УНТЭ-ийн цалин хөлсний журам”, 3. Байгууллагын ерөнхий захирлын 2024.08.28-ны өдрийн А/270 тоот “Журам, жагсаалт, загвар баталж эрхийн түвшин тогтоох тухай” тушаалаар батлагдсан Байгууллагын нууц хамгаалах журам, 4. Байгууллагын ерөнхий захирлын 2022.11.17-ны өдрийн А/336 тоот “Журам батлах тухай” тушаалаар батлагдсан “Баримт бичгийн боловсруулалт, бүртгэл, хяналтын журам” зэрэг эмнэлгийн хэмжээнд нийтээр дагаж мөрдөх ёстой тушаалуудаар нийт ажилтнууд болон шинэ ажилтнуудад зориулсан видео хичээл хийж, нэгдсэн сан үүсгэж эхлээд байна. Тус видео хичээлийг эхний ээлжинд нийт ажилтнуудын албаны цахим хаягаар илгээж нэгдсэн мэдээллээр хангаж байна.
6.5	Хүний нөөц, санхүү, цаг бүртгэлийн Vertich ERP системтэй уялдуулан илүү цаг бодолтыг бодитой тооцоолж системээр боддог болох, программын хөгжүүлэлтийг сайжруулна. **Хэрэгжилтийн хувь 50%**	-	ERP системийн хөгжүүлэлтийн үр дүнд бодож олгосон илүү цагийн нийт дүн	Цаг бүртгэлийг царайгаар таниулах системийг УНТЭ нь 2022.06.02-ны өдрөөс нэвтрүүлсэн. Уг цаг бүртгэлийн системийг хүний нөөц, санхүү, цаг бүртгэлийн Vertich ERP системтэй холбон ажилтнуудын ажлын цагийн ирцэд хяналт тавьж байна. Бид хамтын ажиллагааг өргөжүүлэх, системийн хөгжүүлэлтийг илүү сайжруулах асуудлаар Интерактив ХХК-ийн төлөөлөлтэй Захиргаа, хүний нөөцийн алба нь 2024 онд 2 удаа уулзалт хийж санал солилцсон. Системийг хөгжүүлэхэд нийт 50.0 сая төгрөгийн төсөв шаардлагатай бөгөөд 2025 оны төсвийн төсөөлөлд тусган шийдвэрлүүлэх саналыг удирдлагад танилцуулсан.
6.6	Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээний	-	Төлөвлөгөөний биелэлтийн хувь	УНТЭ-ийн авлигын эсрэг 2024 оны төлөвлөгөөг батлан нийт албан тушаалтнуудад мэдээлж, байгууллагын гадаад цахим хуудсанд байршуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилтийг 2024.05.31-ний өдрийн дотор ЭМЯ-нд хүргүүлсэн. 2024 оны бүтэн жилийн хэрэгжилтийн тайланг 12 сарын 25-ны өдрийн дотор ЭМЯ-нд хүргүүлэхээр бэлтгэж байна.

	төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллана. **Хэрэгжилтийн хувь 90%**			 Зураг. Гадаад сайтанд байршуулсан төлөвлөгөө Эмнэлгийн гадаад цахим хуудас, фэйсбүүк пэйж хуудас, хамт олны дунд ашиглагддаг фэйсбүүк, телеграмм, вайбер группууд, нийтийн эзэмшлийн талбайд байрших мэдээллийн 15 самбар, 6 дэлгэцээр АТГ-ын мэдээлэл, шторк, контент, баннерыг тогтмол байршуулан иргэд болон ажилтнуудыг мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна. Зураг. Фэйсбүүк пэйж хуудсанд байршуулсан мэдээлэл

ЗОРИЛТ 7: Санхүү, төсвийн тогтвортой байдлыг хангах				
7.1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулна, мөрдөн ажиллана. **Хэрэгжилтийн хувь 90%**	15.0 (үйл ажиллагааны орлого)	Шинэчлэгдэн батлагдсан бодлогын баримт бичиг	УНТЭ-ийн Санхүү бүртгэлийн алба нь 2024 оны 05 дугаар сарын 27-ний өдөр Ай Жэй Эй Эйч Аудит ХХК-тай нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт боловсруулж өгөх зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулж, төлбөрийг бүрэн барагдуулсан ба шинэчилсэн бодлогын баримт бичиг хэвлэлтэнд орсон байна.
7.2	Эмийн орлого зарлагыг бар коджуулж, эмнэлгийн ehealth системд бүртгэн, санхүүгийн Veritech системд хөрвүүлж тайлагнадаг болно. **Хэрэгжилтийн хувь 50%**	-	Бүрэн цахимжсан эмийн бүртгэл	Өндөр өртөгтэй хэрэгслийг эмнэлгийн ehealth системд бар код ашиглан орлогодож зарлагадаж эхэлсэн бөгөөд үргэлжлүүлэн шат дараалалтай тарилгын шингэн гэх мэтийг оруулах төлөвлөлттэй ажилласан. 2024 оны сүүлийн хагас жилд ЭМЯ-ны Мэдээлэл технологийн хэлтэс болон Veritech системийн хамтарсан ажлын хэсэг томилогдон ажиллаж эхэлсэн бөгөөд програм хоорондын өгөгдөл солилцох ажил эрчимтэй эхлэн 2025 оны 1 дүгээр улиралд бүрэн шийдэгдэж эрүүл мэндийн салбарт УНТЭ-ийн санхүүгийн програм нь бүрэн нэвтрэх шаардлага хэрэгцээ үүссэн тул эмнэлэг дангаараа 2 систем хоорондын хөгжүүлэлтийг хийж байсныг зогсоосон. 2024 оны 12 сарын 01-ний өдрийн байдлаар эмнэлгийн хэмжээний эмийн цахим бүртгэл 30%-тай, өндөр өртөгт эм, эмнэлгийн хэрэгслийн бүртгэл 70%-тай цахимжсан бөгөөд дундаж хэрэгжилт 50%-тай байна.
7.3	Санхүү бүртгэлийн үйл ажиллагааны нэгдсэн системд хөгжүүлэлт хийнэ. **Хэрэгжилтийн хувь 100%**	-	Хөгжүүлэлт хийсэн тайлан, акт	Санхүү бүртгэлийн Veritech системд шаардлагатай шалгуур үзүүлэлтийг нэмж эм, эмнэлгийн хэрэгсэл, бараа материалыг эхэлж авсанаа эхэлж зарлагдах аргад бүрэн шилжүүлсэн, үндсэн хөрөнгийг бар кодны системд оруулж тооллогыг бар код уншуулан тоолохоор тохируулсан мөн гэрээ, гэрээний гүйцэтгэл бүрэн гардаг болсон ба Санхүүгийн Veritech системд нягтлан бодох бүртгэлийн модуль тус бүрээр нь шаардлагатай хөгжүүлэлтийг нэмж хийн 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар шалгуурыг ажиллуулж 3-р улирлын тайлан тэнцэл дээр туршиж дуусгасан
ЗОРИЛТ 8: Сургалт эрдэм шинжилгээ, судалгаа, гадаад дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх				

8.1	Төгсөлтийн дараах сургалт эрхлэх үйл ажиллагааны холбогдох эрх зүйн баримт бичгийг шинэчилнэ. **Хэрэгжилтийн хувь 90%**	-	– Шинэчлэгдэн батлагдсан журам – Сургалтын хөтөлбөр	УНТЭ-ийн СЭШХАА нь сургалтын үйл ажиллагаандаа ЭМС-ын 2027 оны А/337 тоот “Журам шинэчлэн батлах тухай” тушаалаар батлагдсан сургалт эрхлэгч байгууллагуудын мөрдөн ажиллах журам, Эмнэлгийн захирлын 2020 оны А/201 тоот “Журам шинэчлэн батлах тухай” тушаалаар батлагдсан сургалтын үйл ажиллагааны журмыг мөрдөн ажиллаж байгаа бөгөөд хөдөлмөрийн харилцааны эрх зүйг зохицуулсан хууль, журмууд шинэчлэгдсэнтэй холбоотой эмнэлгийн хэмжээнд мөрдөгдөж буй сургалтын журмыг шинэчлэхээр сургалт эрхлэгч эмнэлзүйн төв, тасгуудаас санал авсан. ЭМС-ын 2017 оны А/337 тоот “Журам шинэчлэн батлах тухай” тушаалаар батлагдсан сургалтын үйл ажиллагааны журамд тусгах 2 удаагийн саналыг ЭМХТ-д албан тоотоор хүргүүлсэн. Тус журам шинэчлэгдсэн тохиолдолд УНТЭ журам шинэчлэгдэхэд бэлэн болсон.
8.2	Эмнэлзүйн сургагч багшийн шалгуур хангасан шаардлагатай эмнэлгийн мэргэжилтнийг сургалтад хамруулна., **Хэрэгжилтийн хувь 100%**	-	– Сургалтад хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний тоо – Гэрчилгээ	Эмнэлзүйн сургагч багшийн шалгуур хангасан эмнэлгийн мэргэжилтний сургалтыг ЭМХТ-өөс зохион байгуулдаг бөгөөд ЭМХТ-ийн даргын 2024.12.11-ний өдрийн 1315 тоот “Сургалтад хамруулах тухай” албан бичгийн дагуу 2024 оны ээлжит сургалтад тус эмнэлгийн эмнэлзүйн албаны дарга болон мэс засал, чих хамар хоолой, эрчимт эмчилгээ, гастроэнтерологи, цус судлал, нүдний 6 эмч нийт 7 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдахаар болсон. Сургалт 12 дугаар сарын 12, 13, 14-ний өдрүүдэд зохион байгуулагдана.
8.3	Төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэх сургалтын чиглэлийн тоог нэмэгдүүлнэ. **Хэрэгжилтийн хувь 100%**	-	Шинээр авсан сургалтын эрх	2024 оны 03 дугаар сарын сарын 29-ний өдрөөс эхлэн Төгсөлтийн дараах сургалтын мэргэжил дээшлүүлэх эмчийн "Дуу авиа судлал"-ын чиглэлээр 5 сарын хугацаатай суралцах сургалтын хөтөлбөрийг шинэчлэн батлуулж, 2024 оны хаврын элсэлтээр 5 суралцагчийг элсүүлэн авч сургаж байна. Дуу авиа судлалын эмчийн мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр Улаанбаатар 2011

8.4	“Эрдмийн чуулган-45” эрдэм шинжилгээний хурал зохион байгуулна. **Хэрэгжилтийн хувь 100%**	15.0 сая төг (үйл ажиллагааны орлого)	Хэвлэгдсэн товхимол	Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн Сургалт, эрдэм шинжилгээ хамтын ажиллагааны албанаас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “ЭРДМИЙН ЧУУЛГАН” эрдэм шинжилгээний хурал 45 дахь удаагаа 2024 оны 05 дугаар сарын 02,03-ны өдрүүдэд амжилттай зохион байгуулагдав. Тус эрдэм шинжилгээний хурал нийгмийн эрүүл мэнд, сувилахуй, дотор, мэс заслын салбарын болон төгсөлтийн дараах сургалтад суралцагч эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн дундах гэсэн 5 салбар хуралдаанаар үргэлжилсэн бөгөөд нийт 67 эрдэм шинжилгээний бүтээл ирүүлснээс 34 бүтээлийг хэлэлцүүлсэн. Хурлын нэгдсэн дүнгээр: **Нийгмийн эрүүл мэндийн салбарын шилдэг оролцогчид:** -Тэргүүн байр: Н.Булган нарын “Эмнэлгийн байгууллагын хэвтэн эмчлүүлэгчдийн өрөөний орчны эд хогшилд дахин ашигладаг цэвэрлэгээний алчуурын халдвар дамжуулах эрсдэлийг судалсан дүн” -Дэд байр: М.Даваасүрэн нарын “Өсвөр үеийн эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлс, урьдчилан сэргийлэх асуудал” -Гутгаар байр: И.Ариунбилэг нарын “Эмчлүүлэгчийн эрүүл мэндийн боловсрол эмийн эмчилгээний үр дүнд нөлөөлдөг эсэхийг үнэлэх асуумж судалгаа” **Сувилахуйн салбарын шилдэг оролцогчид:** -Тэргүүн байр: О.Сарантуяа нарын “Сувилагч, тусгай мэргэжилтнүүдийн хувь хүний хандлагын талаарх судалгаа” -Дэд байр: Б.Цэгмид нарын “УНТЭ-ийн сувилагч нарын унах эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай мэдлэгийг үйлчлүүлэгчийн мэдлэгийн түвшинтэй харьцуулан судлах нь” -Гутгаар байр: П.Энхдэлгэр нарын “УНТЭ-ийн сувилагчдын цусан дахь Д амин дэмийн хэмжээ, хэрэглээг судалсан дүн” **Дотрын анагаах ухааны салбарын шилдэг оролцогчид:** -Тэргүүн байр: Б. Одончимэг нарын “Ковид-19-ийн дараах эмнэлзүйн шинж тэмдэг, ачаалал даах чадварыг судалсан дүн” -Дэд байр: Б.Анхбаяр, Н.Болормаа нарын “Улны хальсны үрэвсэл оноштой үйлчлүүлэгчдийн цохилтод долгионы эмчилгээний үр дүн” -Гутгаар байр: Б.Сумъяа нарын “Элэг шилжүүлэн суулгах мэс засал хийлгэсэн өвчтөнүүдийн дунд үүссэн цөсний замын хүндрэлийг эмнэлзүйн хүчин зүйлстэй нь харьцуулан судалсан дүн” **Мэс заслын анагаах ухааны салбарын шилдэг оролцогчид:** -Тэргүүн байр: Г.Мядаг нарын “Дунгийн суулгацын мэс заслын үргэлжлэх хугацаа, зарим хүндрэлийг чамархайн компьютерт томографын үзүүлэлтүүдтэй уялдуулан судалсан нь”

				-Дэд байр: Д.Энхзул нарын “Хорон даралт ихсэх эмгэгийн үед мэс засал эмчилгээний үр дүнг судлах нь: эмнэлэгт суурилсан нэг төвт ретроспектив судалгаа” -Гутгаар байр: Г.Ганболд нарын “Бөөр, шээсний замын чулууны тархвар зүй өнөөгийн байдал, эрсдэлт хүчин зүйлийн судалгаа” **Төгсөлтийн дараах сургалтад суралцагч эмнэлгийн мэргэжилтнүүдийн дундах салбар хуралдааны шилдэг оролцогчид:** -Л.Ган-Эрдэнэ, С.Нэргүй нарын “Бамбай-хэлний цоргын уйланхай” -Ц.Солонго нарын “УНТЭ-ийн төвөнхийн бичил дурангийн мэс заслын судалгаа” сэдвээр тус тус илтгэл хэлэлцүүлж шалгарав.  Зураг. Шилдэг оролцогч нарт шагнал гардуулсан зураг
8.5	“Эмнэлзүйн ховор тохиолдлын үндэсний чуулган-5” эрдэм шинжилгээний хурал зохион байгуулна. **Хэрэгжилтийн хувь 100%**	15.0 сая төг (үйл ажиллагааны орлого)	Хэвлэгдсэн товхимол	УНТЭ-ийн Сургалт, эрдэм шинжилгээ хамтын ажиллагааны албанаас 2024 оны 11 сарын 29-ний өдөр “ЭМНЭЛЗҮЙН ХОВОР ТОХИОЛДЛЫН ҮНДЭСНИЙ ЧУУЛГАН”-ыг 5 дах жилдээ амжилттай зохион байгуулсан. V дах удаагийн чуулганд 21 аймаг 9 дүүргийн төр, хувийн хэвшлийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдээс нийт 60 тохиолдол ирүүлсэн бөгөөд эхний шатны шалгаруулалтаар шалгарсан шилдэг 20 илтгэлийг аман болон ханын илтгэл хэлбэрээр хэлэлцүүлж шилдгүүдийг тодруулсан. **Аман илтгэлээр:** 1-р байр: "C3 гломерулонефрит" сэдэвт ховор тохиолдлын илтгэлээр УНТЭ-ийн Бөөрний төвийн их эмч Б.Соёл-Эрдэнэ нарын баг; •2-р байр 5"NTRK1 генийн мутациар үүсгэгдсэн өвдөлт үл мэдрэх, үл хөлрөх төрөлхийн эмгэг” сэдэвт ховор тохиолдлын илтгэлээр Б.Мөнхсайхан нарын баг;

				3-р байр: "Салстын меланома" сэдэвт ховор тохиолдлын илтгэлээр Н.Ган-Эрдэнэ нарын баг тус тус шалгарч Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа. **Ханын илтгэлээр:** 1-р байр: "Нүдний лимфома" сэдэвт ховор тохиолдлын илтгэлээр С.Мядагсүрэн нарын баг; 2-р байр: "Зүүн цавины өөхөн эдийн хортой хавдар /consistent with pleomorphic liposarcoma" сэдэвт ховор тохиолдлын илтгэлээр С.Отгонбаяр нарын баг; 3-р байр: "Фелтийн хамшинж" сэдэвт ховор тохиолдлын илтгэлээр Х.Тангул нарын баг тус тус шалгарч Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа. Зураг. Шилдгүүдийн шагналыг гардуулсан зураг
8.6	Төгсөлтийн дараах сургалт эрхэлж буй чиглэлээр Эрүүл мэндийн хөгжлийн төвийн цахим сорилын санг баяжуулна. **Хэрэгжилтийн хувь 100%**	-	Тестийн сангийн баяжилтад хүлээлгэн өгсөн тестийн сан	2024 оны хавар намрын элсэлтийн төрөлжсөн болон мэргэжил дээшлүүлэх сургалтын суралцагчдын төгсөлтийн шалгалтын сорилыг 54 чиглэлийн дагуу чиглэл бүр дээр 100 тест нийт 5400 тестийг сургалт хариуцсан төв, тасгийн зохицуулагч эмч багш, сувилагч багш нартай хамтран боловсруулж ЭМХТ-ийн цахим хуудсанд байршуулж, төрөлжсөн болон дээшлүүлэх сургалтын төгсөлтийн шалгалтуудыг авч байна. 2024 оны хавар, намрын элсэлтээр 54 чиглэлээр 308 суралцагч суралцаж төгссөн.
ЗОРИЛТ 9: Цахим эрүүл мэндийн тогтолцооны хөгжүүлэлт, мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах				

9.1	Серверийн өрөөний UPS-ийг шинэчилнэ. **Хэрэгжилтийн хувь 100%**	80.0 сая төг (үйл ажиллагааны орлого)	Суурилуулсан UPS-ийн тоо	Серверийн өрөөний UPS нь сервер болон сүлжээний тоног төхөөрөмжийн аюулгүй байдал, мэдээллийн нөөц хадгалалт болон үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангахад маш чухал үүрэгтэй. Мэдээлэл технологийн алба нь серверийн өрөөний UPS-ийг шинэчлэх ажлыг 2024 оны худалдан авах ажлын төлөвлөгөөнд тусгаж худалдан авалтыг хийхээр 4 дүгээр сард нээлттэй тендер зарлан, 7 сард UPS буюу тог баригчийн 6 ширхэг батерейг худалдан авч сольсоноор сервер болон сүлжээний аюулгүй байдлыг бүрэн хангасан.
9.2	Эмнэлгийн тасаг, нэгжүүдийг VLAN сүлжээнд хуваана. **Хэрэгжилтийн хувь 100%**	25.0 сая төг (үйл ажиллагааны орлого)	VLAN сүлжээнд хуваасан төв, тасгийн тоо	Эмнэлгийн сүлжээг нийт 38 дэд сүлжээнд хуваан төлөвлөсөн бөгөөд 2024 оны эхний байдлаар 13 дэд сүлжээг тасаг нэгжүүдэд бүрэн нэвтрүүлж, сүлжээний ачааллыг багасгасан. Бусад тасаг нэгжүүдийг дэд сүлжээнд /vlan/ хуваахад шаардлагатай тохируулгатай салаалагчууд /managed switch/-ийн худалдан авалтыг 7 дугаар сард нээлттэй тендер зарлан зохион байгуулсан бөгөөд төлөвлөсний дагуу 38 дэд сүлжээнд бүрэн хуваасан. Ингэснээр тасаг нэгжүүдийн сүлжээ хэсэгчлэн болон бүрэн тасрахад гэмтэл тодруулах, засварлах хугацааг багасгах, нэг тасагт гарсан гэмтлээс шалтгаалж бусад тасгуудын үйл ажиллагаа доголдох зэргээс сэргийлж, сүлжээний хэвийн үйл ажиллагааг хангаж байна. Сүлжээний аюулгүй байдал талаас дэд сүлжээнүүдийг хязгаарласан хандалт хийх боломжийг бүрдүүлсэн бөгөөд тодорхой хэсгийн төхөөрөмжүүд зөвхөн өөрийн VLAN-ийн хүрээнд холбогдож, бусад хэсэгтэй шууд харилцаж чадахгүй давуу талтай.
9.3	Эм эмнэлгийн хэрэгслийн бүртгэлийг баркоджуулан зарцуулалтыг цахим хэлбэрт оруулна. **Хэрэгжилтийн хувь 100%**	-	Баркоджуулсан өндөр өртөгтэй хэрэгслийн тоо	УНТЭ-ийн Мэдээлэл технологийн алба, Эм зүйн алба, Санхүү бүртгэлийн алба, Эмнэлгийн хэрэгсэл, аж ахуй хангамж түгээлтийн албаны холбогдох мэргэжилтнүүд Өндөр өртөгт эмнэлгийн хэрэгсэл тусламж үйлчилгээндээ ашигладаг эмнэлзүйн төв тасгууд болох Мэдээгүйжүүлэг хагалгааны нэгдсэн тасаг, Дүрс оношилгооны төвтэй хамтран эмнэлэгт худалдан авалт хийгдсэн өндөр өртөгтэй эмнэлгийн хэрэгслийн нэршил болон дахин давтагдашгүй кодоор программ бүртгэн тухайн хэрэгслийг баркод уншуулан зарцуулалтыг хэрэглэж буй үйлчлүүлэгчийн өвчний түүхэнд хавсрагддаг байдлаар программ нэмэлт хөгжүүлэлт хийж  бүртгэл зарцуулалтыг үйл ажиллагааг цахимаар хийж хэвшүүлсэн.Нийт 1000 гаруй өндөр өртөгтэй эмнэлгийн хэрэгслийг баркодоор программ бүртгэсэн.

9.4	Амбулаторийн хэсэгт бичигдэж буй эмийн жорыг цахимжуулна. **Хэрэгжилтийн хувь 100%**	-	– Батлагдсан тушаал шийдвэр – Журам	Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар Эрүүл мэндийн салбарт цахим шилжилтийг эрчимжүүлэх аяны хүрээнд “Эмийн жор бичих” үйлчилгээг eHealth программд шинэчлэн оруулж өгснөөр эмч eHealth программаар үйлчлүүлэгчийн эмийн жорыг бичих, иргэд үйлчлүүлэгч e-Mongolia системд нэвтэрч эмийн жороо авах боломж бүрдсэн. Тухайлбал эмч жороо eHealth програм дээр бичихэд шууд e-Mongolia системд бүртгэгдэж үйлчлүүлэгчийн гар утсанд мэдэгдэл ирдэг болсон. Цахим жорыг системд оруулснаар эмийн санч цаасан жор шаардахгүйгээр цахим системийн дагуу иргэдэд үйлчлэх, эмийн жорыг гараар бичихээр гаргац муутайгаас буруу эм өгөх тохиолдолд гардаг байсан асуудал арилах давуу талтай болж байна. 
ЗОРИЛТ 10: Гамшгийн үеийн бэлэн байдлыг ханган ажиллах, шинэ болон сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх				
10.1	УНТЭ-ийн “Болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх ерөнхий төлөвлөгөө”-г тодотгол хийн батлуулна. **Хэрэгжилтийн хувь 100%**	-	Тодотгол хийж баталсан арга хэмжээний төлөвлөгөө	УНТЭ-ийн “Болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах, нөхөн сэргээх ерөнхий төлөвлөгөө”-г Эмнэлгийн захирлын 2023 оны А/149 тоот “Болзошгүй аюул ослоос сэргийлэх, бэлэн байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” тушаалаар баталсан. 2024 онд төлөвлөгөөнд дахин тодотгол хийж 03 дугаар сарын 21-ний өдөр Сүхбаатар дүүргийн ОБЕГ-ын Онцгой байдлын хэлтсийн дарга хурандаа А. Бэхбаяраар хянуулсан. Эмнэлгийн ерөнхий захирал 9 сард шинээр томилогдсонтой холбоотой тус төлөвлөгөөг эмнэлгийн захирлын 2024 оны А/403 тоот “Болзошгүй аюул ослоос сэргийлэх, бэлэн байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” тушаалаар дахин шинэчлэн баталсан. Төлөвлөгөө нь 5 хавсралттай. ➢ **НЭГДҮГЭЭР ХАВСРАЛТ:** Шуурхай зарлан мэдээлэх өнгөт дохиоллын тогтолцоо, штабын бүрэлдэхүүний схем ➢ **ХОЁРДУГААР ХАВСРАЛТ:** Штабын бүтэц бүрэлдэхүүн, гишүүдийн ажил үүргийн хуваарь ➢ **ГУРАВДУГААР ХАВСРАЛТ:** Мэргэжлийн ба хангалтын анги, хөдөлгөөнт отрядын бүрэлдэхүүн, ажил үүргийн хуваарь

				➢ **ДӨРӨВДҮГЭЭР ХАВСРАЛТ:** Болзошгүй осол аюулаас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ, нөхөн сэргээх ажиллагааны төлөвлөгөө Нэгдүгээр бүлэг. УНТЭ-ийн танилцуулга, чадамж, нөөц боломж Хоёрдугаар бүлэг. Болзошгүй аюул ослын улмаас эмнэлэгт үүсч болох эрсдэлийн баримжаа Гуравдугаар бүлэг. Болзошгүй аюул, ослын үеийн цагийн байдлын төлөвлөгөөнүүд ➢ **ТАВДУГААР ХАВСРАЛТ:** 5.1. Газар хөдлөлтийн гамшгаас сэргийлэх бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ, нөхөн сэргээх ажиллагааны ерөнхий төлөвлөгөө 5.2. Гал түймрийн аюул ослоос сэргийлэх бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ, нөхөн сэргээх ажиллагааны ерөнхий төлөвлөгөө 5.3. Шинэ болон сэргэж буй халдварт өвчин дэгдэлтээс урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ, нөхөн сэргээх ажиллагааны ерөнхий төлөвлөгөө, /COVID-19 үед ажиллах төлөвлөгөө/ 5.4. Зүрх зогсож, амь тэнссэн байдлын үед эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх бэлэн байдлын төлөвлөгөө 5.5. Мэдээллийн аюулгүй байдал /Цахим мэдээллийн сан, архив/-ыг хангах төлөвлөгөө
10.2	Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг шинэ болон сэргэж буй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үзүүлэх сургуулилалт зохион байгуулна. **Хэрэгжилтийн хувь 100%**	-	– Үзүүлэх сургуулилалт хийсэн тайлан – Хамрагдсан ажилтны тоо	Тайлант хугацаанд буюу 2024 онд Халдварын сэргийлэлт, хяналтын албанаас ЭМС-ын 2018 оны А/527 тоот тушаалын дагуу шинэ болон сэргэж буй халдварт өвчний дэгдэлтээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг тогтмол ханган ажиллаж УНТЭ-т ирсэн халдварт болон халдварт бус өвчинд тандалт судалгааг тогтмол хийн хариу арга хэмжээг шуурхай авч ажиллаж байна. Тайлант хугацаанд УНТЭ-т халдварт өвчний нийт 26 тохиолдол бүртгэгдсэн байна. Үүнд: ➢ Сүрьеэгийн халдварын 15 тохиолдол ➢ HIV-р үүсгэгдэх халдварын 3 тохиолдол ➢ Салхинцэцгийн вирусээр үүсгэгдэх халдварын сэжигтэй 1 тохиолдол ➢ Хачгаар дамжих халдварын сэжигтэй 6 тохиолдол ➢ Коронавируст халдварын батлагдсан 1 тохиолдол Эдгээр тохиолдлуудыг ЭМС-ын А/527 тоот тушаал болон ЭМС-ын А/160 тоот тушаалуудыг үндэслэн холбогдох дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Үүнд: ➢ Тусгаарлан шилжүүлэх арга хэмжээ ➢ Тархвар судлалын судалгааны хуудсаар үнэлгээ нийн дүгнэлт гаргах ➢ Шинжилгээнд хамруулах ➢ Сорьцыг илгээх ➢ Урьдчилан сэргийлэх, ариутгал халдваргүйтгэл хийх

				➢ Голомтын ариутгал халдваргүйтгэл хийх ➢ Халдваргүйтгэлийн дараах цэвэрлэгээ Мөн Монгол Улсад Улаанбурхан өвчний 1 тохиолдол 2024 оны 07 сарын 31-ний өдөр лабораториор батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн яамны 2024 оны 08 сарын 02-ны өдрийн дугаар 2/3174 албан тоот “Тандалт эрчимжүүлэх тухай” мөн Эрүүл мэндийн сайдын 2024 оны 08 сарын 07-ны өдрийн дугаар/03 “Улаан бурхан өвчний тархалтаас сэргийлэх хариу арга хэмжээний тухай” албан даалгаврыг тус тус хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараа 8 чиглэлээр үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан. 1. **ТАНДАЛТ СУДАЛГААНЫ ЧИГЛЭЛЭЭР:** Тайлант хугацаанд ЭМС-ын А/91 тоот тушаалыг үндэслэн улаанбурхан халдварт өвчин тархах эрсдэлээс сэргийлэн эмнэлзүйн шинж тэмдгийн тандалтыг хуудсыг боловсруулж амбулатори, яаралтай тусламжийн тасаг, шуурхай зохион байгуулалтын хэсэг, эрүүл мэндийн даатгалын хэсгүүдэд байршуулан тандалт хийх ажилтныг тусад нь томилж хэвтэн эмчлүүлэгчдийг шинж тэмдэггүй тохиолдолд тандалтын хуудсыг нээж өвчний түүхэнд хавсарган тасагт хэвтсэн өдрөөс гарах хүртэлх хугацаанд өдөр бүр тандалт судалгаа хийж байсан бөгөөд эмнэлгийн ажилчдын дундах тандалтыг ЭМТҮЧАБА-нд мэдээлж сэжигтэй тохиолдолд холбогдох албанд хүргүүлэн шуурхай хариу арга хэмжээг хэрэгжүүлж байна. 2. **СУРГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:** ЭМС-ын А/537, А/91, А/528 тоот тушаалуудыг үндэслэн Улаан бурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх, авах хариу арга хэмжээний талаарх хичээлийг бэлтгэн 2024 оны 08 сарын 04,07,08,13,14 өдрүүдэд эмнэлгийн төв тасаг, дэмжих албадуудын нийт эмч ажилчдад сургалтыг үе шаттайгаар зохион байгуулсан. Сургалтанд нийт 485 эмч ажилтнууд хамрагдсан байна. Мөн ХСХА нь ЗӨСҮТ-тэй хамтран Яаралтай тусламжийн тасагт шинэ болон сэргэж буй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үзүүлэх сургуулилалтыг зохион байгуулсан. 3. **ГАМШГИЙН ҮЕИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТОДОТГОЛЫН ЧИГЛЭЛЭЭР:** Эмнэлгийн гамшгийн үед авах хариу арга хэмжээ, бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийж халдварын сэжигтэй тохиолдолд эмнэлэг дотор ямар хариу арга хэмжээ авах, халдварын тархалтын түвшинг хэрхэн бага байхаар зохион байгуулах талаар эмнэлзүйн багаараа хэлэлцэн 3 төрлийн алгоритмийг боловсруулж төв тасгуудад байршуулсан.

				4. **ТУСГААРЛАХ ӨРӨӨНИЙ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:** Дээрх тушаалуудыг үндэслэн халдварын сэжигтэй, халууралт, тууралттай тохиолдлыг тусгаарлан яаралтай мэдээлэх зохион байгуулалтыг хийж яаралтай тусламжийн тасаг, эрчимт эмчилгээний тасаг, хэвтэн эмчлүүлэх тасгуудад тус бүр тусгаарлах өрөөг бэлтгэн бэлэн байдлыг хангуулсан. 5. **ЦЭВЭРЛЭГЭЭ ХАЛДВАРГҮЙТГЭЛ, АГААР ДУСЛЫН ЗАМААР ХАЛДВАР ДАМЖИХААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР**: Халдвар агаар дуслаар дамжин тархахаас сэргийлж эмнэлгийн хэмжээнд төв, тасаг тус бүрээр хуваарь гарган агаарт халдваргүйтгэлийг тогтмол хийлгэн, тасгуудын дотоод талбайн их цэвэрлэгээний давтамжийг нэмэгдүүлэн ажилласан. 6. **ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ, ХАМГААЛАХ ХУВЦАС ХЭРЭГСЛИЙН НӨӨЦИЙН БЭЛЭН БАЙДАЛЫГ ХАНГУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:** Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эрүүл мэндийн байгууллагын нөөцөд байх эм эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйтгэлийн бодис, оношлуурын нөөцийн мэдээг 2024 оны 08 сарын 08-ны өдрөөс эхлэн өдөр бүр 9 цагт ЭМТҮЧАБА-нд мэдээлсэн. 7. **ЭМЧ,ЭМНЭЛГИЙН АЖИЛТНУУДЫГ ДАРХЛААЖУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР:** Эмнэлгийн хэмжээнд дархлаажуулатын талаар судалгаа хийж, нийт 320 эмч ажилтнуудыг улаан бурхан өвчний эсрэг вакцинаар вакцинжуулсан. 8. **МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ЗӨВЛӨМЖ ХҮРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:** УНТЭ-ийн байгууллагын мэдээллийн сувгууд болох гадаад вэб хуудас, фэйсбүүк пэйж (Улсын Нэгдүгээр Төв эмнэлэг, УНТЭ Нийгмийн Эрүүл Мэндийн Алба) хуудсуудаар дамжуулан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг өдөр бүр тогтмол байршуулан түгээсэн.
10.3	A,B,C,D блокуудын нийтийн эзэмшлийн талбайд галын утаа мэдрэгч, дохиоллын систем, стикер, галын булан тавьж галын	-	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь, ажлын тайлан	Тус ажлын нийт төсөв 35.0 сая төгрөг байсан бөгөөд 2024 онд санхүүжилтийн асуудал хүндрэлтэй болсон тул тус ажлууд хийгдээгүй. 2025 оны төсөвт дахин тусгаж хийхээр төлөвлөсөн. 2024 оны I дүгээр улиралд Инженерийн байгууламжийн алба, Сувилахуйн албадууд хамтарч нийт ажилтнуудын тэсэрч дэлбэрэх, галын аюулаас урьдчилан сэргийлэх, мэдлэг, чадварыг дээшлүүлэх зорилгоор галын хорыг хэрхэн зөв хэрэглэх, галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар маш ойлгомжтой мэдээлсэн зурагт хуудас гарган “Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн хамт олон” FB групп, төв тасгийн эрхлэгч нарын Viber групп, ахлах сувилагч болон нийт сувилагч нарын telegram группт мэдээллийг байршуулж ажилласан.

	аюулгүй байдлыг хангана. **Хэрэгжилтийн хувь 70%**			Эмнэлгийн хэмжээнд галын аюулгүй ажиллагааны самбар 5 байрлалд, галын хорны аюулгүй ажиллагааны зааварчилгаа 30 байрлалд байршуулсан бөгөөд нийт 95 галын хор байрлуулсан. Мөн Сувилахуйн алба, ЗАА-ны ХАБЭА-н ажилтан нар хамтарч 2024 оны 2 дугаар сарыг галын аюулгүй байдлыг сайжруулахын тулд “Тэсэрч дэлбэрэх, галын аюулаас урьчилан сэргийлэх” сар болгон зарлаж, 2-р сарын 22,23-ны өдрүүдэд “Галын хороор галыг хэрхэн унтраах” тухай дадлага сургалтыг СБД-ийн Гал түймэр унтраах, аврах 44-р ангитай хамтран явуулж нийт 150 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсан. Зураг. Дадлага сургалтын үеийн зураг
10.4	Эмнэлэг доторх “Blue code идэвхижүүлэх, эрчимжүүлэх үнэлгээг идэвхижүүлэх шуурхай үйлдлийн баг” байгуулах, ажиллах журмыг боловсруулж батлуулах, сургалт зохион байгуулна. **Хэрэгжилтийн хувь 100%**	-	– Баг байгуулсан журам – Хийсэн ажлын тайлан	Эмнэлэг доторх “Blue code идэвхижүүлэх, эрчимжүүлэх үнэлгээг идэвхижүүлэх шуурхай үйлдлийн баг” байгуулах, ажиллах журмыг боловсруулж батлуулах, сургалт зохион байгуулах ажлын хүрээнд 2024 онд дараах ажлуудыг хийж хэрэгжүүлсэн: 1. УНТЭ-ийн Яаралтай тусламжийн тасгаас боловсруулан, эмнэлгийн захирлын 2024 оны 6 сарын 17-ны өдрийн А/192 тоот тушаалаар “Эмнэлэг доторх ХӨХ КОД идэвхижүүлэх үйл ажиллагааны журам” батлагдсан.  Зураг. Батлагдсан журам

				2. УНТЭ-ийн Яаралтай тусламжийн тасгаас эмнэлгийн хэмжээнд “**ХӨХ КОД**”, “**АМИЛУУЛАХ СУУРЬ ТУСЛАМЖ**” сургалтыг 2024 оны 3, 4-р сарын хугацаанд зохион байгуулж, нийт 152 эмч, 256 сувилагч нар хамрагдсан. 3. УНТЭ-ийн Яаралтай тусламжийн тасгаас эрхлэн Сувилахуйн алба, ЭМТҮЧАБА-ууд хамтран 2024 оны 03, 04 дүгээр сарыг амилуулах суурь тусламжийн сургалт зохион байгуулах, хөх кодыг идэвхижүүлэх сар болгон 2 сарын аян зарласан бөгөөд аяны хүрээнд Сувилахуйн албанаас тус 2 сарын аяныг дэмжин дараах ажлуудыг зохион байгуулсан бөгөөд ажил мэргэжлийн уралдаан зохион байгуулсан. 1) Аяны хүрээнд хөх код идэвхижүүлэх, эрчимжүүлэх, үнэлгээг идэвхижүүлэх талаар мэдээлсэн постер, баннер, самбар гаргаж байршуулах, нийт эмч сувилагч нарыг аяны талаар мэдээллээр хангах 2) Амилуулах суурь тусламж үзүүлэх бэлэн байдлын судалгааг хийх 3) Цэнхэр код идэвхижүүлэх үеийн үйл ажиллагааны журмыг боловсруулан батлуулах 4) Яаралтай тусламжийн тэргэнцэр, цүнхний бэлэн байдлын жагсаалтыг шинэчлэн, шалгуур хуудас гаргах ажлуудыг тус тус зохион байгуулсан. Зураг: Хөх код сургалт явагдаж буй нь 4. Тус 2 сарын хугацаанд өрнөсөн аяны үйл ажиллагааны үргэлжлэл болгож, сургалтын үр дүнг сайжруулахын тулд Сувилахуйн албанаас Олон Улсын Сувилагчийн өдрийг угтан “АМИЛУУЛАХ СУУРЬ ТУСЛАМЖ, ХӨХ КОД КОД ИДЭВХЖИХ ҮЕИЙН АРГА ХЭМЖЭЭ” ажил мэргэжлийн уралдааныг 2024 оны 05 сарын 10-ны өдөр сувилахуйн багуудын дунд дараах 6 өртөөгөөр зохион байгуулж уралдаанд тус бүр 5 хүний бүрэлдэхүүнтэй 16 сувилахуйн баг оролцож мэдлэг, мэргэжлийн ур чадвараа сорьсон.

				➢ Өртөө 1 - Багийн ахлагчийн тэмцээн ➢ Өртөө 2 - Нэг аврагчтай амилуулах суурь тусламж үзүүлэх ➢ Өртөө 3 - Өвчтөний амин үзүүлэлт хянах, мониторт ажиглах ➢ Өртөө 4 - Амьсгалын замыг чөлөөлөх, амьсгал өгөх ➢ Өртөө 5 - Гэмтэгсдийг аврах үеийн сувилахуйн тусламж ➢ Өртөө 6 - Багаар амилуулах суурь тусламж үзүүлэх гэсэн гэсэн төрлөөр зохион байгуулав.
ЗОРИЛТ 11: Хөрөнгө оруулалт				
11.1	Эмнэлгийн төв барилгын гадна фасадыг шинэчилнэ. **Хэрэгжилтийн хувь 90%**	3,1000.0 (улсын төсөв)	Гэрээ, ашиглалтад оруулсан акт, дүгнэлт	Эмнэлгийн төв барилгын гадна фасадыг хийх ажлын тендерийг ЭМЯ-наас зарлаж, 2024.05.21-ний өдөр тендерийн бичиг баримтыг үнэлж, “БИ РИЙЧ ТРЕЙД” ХХК шалгарсан. Гэрээ байгуулах шатандаа явж байна.
11.2	Амбулаторийн хэсгийн хэрэгцээний цэвэр, бохир усны шугамын засварыг хийж, цахилгаан шат суурилуулна. **Хэрэгжилтийн хувь 90%**	1,6000.0 (улсын төсөв)	Гэрээ, ашиглалтад оруулсан акт, дүгнэлт	Амбулаторийн хэсгийн хэрэгцээний цэвэр, бохир усны шугамын засварыг хийж, цахилгаан шат суурилуулах ажлын тендер нь ЭМЯ-наас зарлагдсан бөгөөд тус ажлын батлагдсан төсөв нь 2019 онд хийгдсэнээр байгаа бөгөөд шаардлагатай төсвийг шинэчлэн хийсэн. 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар ЭМЯ-наас тендер зарлах ажил явагдаж байна.
11.3	Шинээр баригдаж, шинэчлэгдэж буй хүчилтөрөгчийн үйлдвэрийг хүлээж авч	-	Барилгын гүйцэтгэлийн хувь	Тус ажил нь Нэгдсэн Үндэсний Байгууллагын хүүхдийн сангийн тусламжаар хийгдэж байгаа бөгөөд эмнэлгийн хүчилтөрөгчийн үйлдвэрийн барилгын 2023 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн МЗХ2024/04-022 дугаартай Архитектур төлөвлөлтийн даалгаврын дагуу 122,2 м.кв талбай бүхий 1 давхар барилгыг стандартын дагуу барьж, улсын коммис ажиллуулахад бэлэн болсон буюу барилгын гүйцэтгэлийн хувь 100%.

	ашиглалтад оруулна. **Хэрэгжилтийн хувь 100%**			Теслийн төлөвлөгөөний дагуу хүчилтөрөгчийн үйлдвэрийн тоног төхөөрөмж угсралтын ажил эхлэхэд бэлэн болоод байгаа бөгөөд 12 сардаа багтаан угсралт суурилуулалтыг хийж гүйцэтгэнэ.

ТАЙЛАН ХЯНАСАН: ЗАХИРЛЫН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА **Ц.АМАРЖАРГАЛ**

ТАЙЛАН БИЧСЭН: ЗАХИРЛЫН АЖЛЫН АЛБАНЫ ДХМ/ХШҮМ **Б.ЭНХТУУЛ**